

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр, Пүрэв гараг*

**Хуралдааны тэмдэглэлийн агуулга**

**Хуралдааны товч тэмдэглэл:** 1-6

**Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:** 7-46

---

1. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.01.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ 7-46

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
Эдийн засгийн байнгын хорооны  
2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр /Пүрэв гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 27 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: П.Батчимэг, Ч.Лодойсамбуу, О.Цогтгэрэл;  
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, Ш.Бямбасүрэн, Ж.Ганбаатар;  
Тасалсан: Х.Баттулга, Х.Ганхуяг.

**Нэг.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.01.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Цолмон, мөн газрын Хууль, эрх зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Саруул, ахлах шинжээч Б.Төрбат, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх Б.Ганбат, Б.Хулан, М.Цэлмүүн, Үндэсний статистикийн хорооны Нэгдсэн статистикийн газрын дарга Ц.Тэгшжаргал, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, мөн газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ерөнхий аудитор О.Баярмагнай, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн багш Г.Давааням нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Хууль зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Г.Агар-Эрдэнэ, П.Амаржаргал, Ж.Бямбадулам, Н.Мөнхзэсэм, Ж.Сайнхишиг, Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хууль зүйн дүн шинжилгээний хэлтсээс гаргасан хууль зүйн дүгнэлтийг Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур нар танилцуулав.

Хуралдаан 09 цаг 58 минутаас 10 цаг 10 минутад завсарлав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл, Р.Батболд, М.Энхцэцэг, П.Сайнзориг, Э.Батшугар, Б.Энхбаяр, Д.Энхтүвшин,

М.Мандхай, М.Бадамсүрэн нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Цолмон, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ерөнхий аудитор О.Баярмагнай, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн багш Г.Давааням нар хариулж, тайлбар хийв.

*Хуралдаан 11 цаг 39 минутаас 12 цаг 05 минутад завсарлав.*

Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг, Р.Батболд, П.Сайнзориг, М.Бадамсүрэн, Р.Сэддорж нар үг хэлэв.

**Р.Сэддорж:** 1.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17  
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

*Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёлын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.*

2.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 5  
Бүгд: 17  
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 5  
Бүгд: 17  
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

*Улсын Их Хурлын гишүүн М.Мандхайн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.*

4.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 5  
Бүгд: 17  
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Дампуурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17  
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 5  
Бүгд: 17  
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

*Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл, М.Мандхай нарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.*

7.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17  
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Инновацийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 6  
Бүгд: 17  
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

*Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.*

10.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 7  
Бүгд: 17  
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17  
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17  
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17  
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 5

Бүгд: 17  
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 5  
Бүгд: 17  
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17  
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 5  
Бүгд: 17  
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 5  
Бүгд: 17  
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

*Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.*

19.Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8

Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 7  
Бүгд: 17  
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

*Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.*

21.“Хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17  
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 12 цаг 33 минутад хэлэлцэж дуусав*

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 2 цаг 28 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 68.0 хувийн ирцтэйгээр 12 цаг 33 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
ЭДИЙН ЗАСГИЙН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр,  
Пүрэв гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим  
09 цаг 27 минут.

### **ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Р.Сэддорж:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Хуралдааны эхэнд өнгөрсөн амралтын өдрүүдээр Байнгын хорооны гишүүд 9 гишүүн уул уурхайн Монгол Улсын эдийн засагт томоохон нөлөө үзүүлдэг төслүүдтэй танилцаж ирсэн Оюу толгой. Мөн экспортын хамгийн том боомт болох Гашуунсухайтын боомт, хил холболтын шаардлагатай байгаа хил холболтын 2 цэг дээр ажилласан. Мөн Тавантолгой Төмөр зам хэмээх 250-аад километр төмөр замын үйл ажиллагаатай танилцсан. Эрдэнэс Тавантолгой компани, орон нутгийн өмчийн Тавантолгой компанийн лицензийн талбай дээгүүр ажилласан. ЭТТ компанийн нүүрс баяжуулах 10 сая тонны хүчин чадалтай нүүрс баяжуулах үйлдвэрийг очиж үзсэн. Ийм ажлуудыг зохион байгуулж, сум орон нутгийн удирдлагуудтай уулзаж, тулгамдсан асуудлуудыг газар дээр нь танилцаж ирсэн. Байнгын хорооны гишүүддээ баярлалаа. Дараагийн томоохон төслүүдтэй хийх ажлуудыг гишүүдийн саналаар ажлын алба зохион байгуулна.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдээ танилцуулъя. Улсын Их Хурлын хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Сэддорж, Батболд, Батнайрамдал Батшугар, Лувсанжамц, Мандхай, Мөнхсоёл, Сайнзориг, Соронзонболд, Ундраа, Найдалаа, Энхтүвшин, Энхцэцэг нарын гишүүд хүрэлцэн ирж оролцож байна. Эмнэлгийн чөлөөтэй Алдаржавхлан гишүүн, Бямбасүрэн, Ганбаатар гишүүд, мөн чөлөөтэй Батчимэг, Лодойсамбуу гишүүд байна. Хуралдааны ирц 52 хувьтай байна. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 52 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүд, ЗГ-аас 2025 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр өргөн барьсан, хэлэлцэх эсэх. Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё. Бид 9 цаг 50 минутаас хуралдаанаа түр завсарлуулж, нэгдсэн чуулганы хуралдаанд оролцож, эхний эмгэнэл илэрхийлэхэд чуулганыхаа нэгдсэн хуралдаанд байхаар ярилцлаа. Ингээд маргааш гашуудлын өдөр зарласан. Өнөөдөр чуулганы нэгдсэн хуралдаанаар эхний минутуудад эмгэнэл илэрхийлэх юм байна.

Хэлэлцэх асуудал 1. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулъя. Хуулийн төслийн талаарх хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Их



Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга Ням-Осорын Учрал танилцуулна. Сайдын микрофоныг нээе.

**Н.Учрал:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Алсын хараа 2050 Урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-ээс 2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.2.19-д төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлж, өмч хувьчлалыг үе шаттай үр дүнтэй явуулна гэж, Шинэ сэргэлтийн бодлогын 6.4-д төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашиг засаглалыг сайжруулж, олон нийтийн шууд хяналтад оруулах ажлыг зохион байгуулна гэж тус тус заасан.

Монгол Улсын Засгийн газрын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт ТӨК-ийн засаглалыг сайжруулах зорилтыг тэргүүлэх чиглэлээ болгон хөтөлбөрийн 3.4.1.2.4-д төрийн болон орон нутгийн өмчит компаниудын засаглал, ил тод байдлыг сайжруулж, олон улсын менежментийн багаар удирдуулж, нээлттэй ХК болгон үр ашиг, баялгийн тэгш хуваарилалтыг нэмэгдүүлнэ гэж, 4.1.4.2-т төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийг улс төрөөс хараат бус, нээлттэй, ил тод, зах зээлийн зарчмаар үйл ажиллагаа явуулах тогтолцоог бүрдүүлье гэсэн зорилтыг дэвшүүлсэн. Энэ хүрээнд Монгол Улсын Засгийн газар Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах, олон улсын компанийн сайн засаглалын зарчмыг нэвтрүүлэх, хяналт, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх зорилгоор төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулахтай холбоотой тухайлсан харилцааг зохицуулах хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төслийн хүрээнд дараах тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхийг зорьж байна. Нэгд төрийн болон орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулах үндэслэл, журам, шалгуурыг тодорхой болгоно.Төр орон нутагт тооцоо судалгаагүйгээр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийг үүсгэн байгуулж, хувийн хэвшилтэй өрсөлдөж, зах зээлд оролцож байгаа нь эдийн засаг дахь хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх өрсөлдөөнийг дэмжихэд сөргөөр нөлөөлж байна. Улсын төсөвтэй дүйцэхүйц хэмжээний төсвийг ТӨК, үйлдвэрийн газрууд захиран зарцуулж байгаа ч эзэмшиж байгаа хөрөнгө санхүүгийн эх үүсвэртэй харьцуулахад ашигт ажиллагаа, өгөөжийн түвшин бага, санхүүгийн сахилга бат сул, үр ашиггүй, их хэмжээний алдагдалтай ажиллаж байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 99 хуулийн этгээдийн ашиг, алдагдлыг багцалж үзвэл нийт цэвэр ашгийн дүнгийн 4,75 их наяд төгрөгийг ЭТТ компани, Эрдэнэт үйлдвэр, Эрдэнэс Монгол, Хөдөө аж ахуйн корпорац, Төрийн банк нийлээд 4,75 их наяд төгрөгийг, 380 тэрбум төгрөгийг бусад 51 хуулийн этгээд бүрдүүлсэн байна. Харин үлдсэн 43 хуулийн этгээд нь алдагдалтай ажилласан ба алдагдлын нийт хэмжээ 150 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Түүнчлэн 2023 оны аудитлагдсан санхүүгийн тайланд үндэслэн эрсдэлийн ерөнхий үнэлгээг ОУВС-ийн ашиглалтыг санхүүгийн шалгуур үзүүлэлтийн дагуу тооцож үзэхэд хөрөнгийн өгөөж дунд эрсдэлтэй буюу 0-5 хувийн хооронд үзүүлэлттэй 23, өндөр эрсдэлтэй буюу 5 хувиас доогуур үзүүлэлттэй 20 хуулийн этгээд байна. Иймд санхүүгийн алдагдалтай ажилласан, бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаагүй, гүйцэтгэлийн үнэлгээ болон аудитын дүгнэлтээр

хангалтгүй ажилласан төрийн болон орон нутгийн өмчит компанийн удирдлагад хариуцлага хүлээлгэх, компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах арга хэмжээ авах зохицуулалтыг хуулийн төсөлд тусгалаа.

2.Төрийн зохицуулах болон өмчлөлийн бодлого салангид байх зарчмыг баримтална. ТӨК-ийн бизнесийн үйл ажиллагаанд төр хөндлөнгөөс оролцох, удирдлагыг томилох, улс төрийн шийдвэр гаргах, төсвийн шинжтэй зардлыг санхүүжүүлэх зэргээр сөргөөр нөлөө үзүүлж байна. Эдийн засгийн харилцаанд төр зохицуулагчийн хувиар оролцох бодлогыг баримталдаг хэдий ч зах зээлийн эдийн засгийн тогтолцоотой улс орнуудад нийтлэг мөрдөгддөг төрийн зохицуулах болон өмчлөгчийн бодлого салангид байх зарчим алдагдаж, төр, аж ахуй, бизнесийн үйл ажиллагаанд хэт анхаарал хандуулснаар тухайн салбарын бизнес, хөгжлийн стратеги, бодлого, төлөвлөлтийг тодорхойлох, төлөвлөх, хэрэгжүүлэх үндсэн чиг үүргээ саармагжуулах, нөгөө талаас хувийн аж ахуй эрхлэгчдэд тэгш бус хандах, шударга бус өрсөлдөөнийг бий болгох, эдийн засаг дахь хувийн хэвшлийн орон зай хумих нөхцөлийг бүрдүүлж байна.

3.Ил тод, нээлттэй байдлыг хангана. Төрийн болон орон нутгийн өмчит компани үйл ажиллагаандаа компанийн засаглалын зарчим кодексыг хэрэгжүүлдэггүй, санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан ил тод бус, мэдээлэл нээлттэй биш байна. Иймд төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагаанд хамааралтай нийт 74 төрлийн мэдээллийг цахим хуудсандаа ил тод нээлттэй болгох үүргийг хатуу хуульчилж өгнө.

4.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг тодорхой болгоно. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн зохион байгуулалт, эрх зүйн хэлбэрийг Иргэний хуульд зааснаас өөрөөр буюу аж ахуйн шинжтэй үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн тооцоотой эсхүл улсын төсвөөс санхүүждэг УТҮГ хэлбэрээр байгуулж, үйл ажиллагаа явуулж байгаа нь хуулийн этгээдийн засаглал зохицуулалтыг ойлгомжгүй болгож байна. Иймд төрийн өмчит үйлдвэрийн газрын хэлбэрийг хуулийн этгээдийн төрлөөс хасаж, аж ахуйн тооцоот төсөвт үйлдвэрийн газрыг компанийн хэлбэрт шилжүүлэх, төсвөөс санхүүжүүлдэг улсын төсвийн үйлдвэрийн газрыг нийтийн үйлчилгээний байгууллага хэлбэрээр өөрчлөн зохион байгуулна.

5.Мэргэжлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлж, улс төрийн томилгоог хална. Уул уурхайн компаниудыг Эрдэнэс Монгол нэгдэл буюу холдингийн зарчимд, уул уурхайн бус компаниудын үйл ажиллагааг Эрчист Монгол нэгдэлд менежментийн зохистой удирдлагыг хэрэгжүүлнэ. Энэ хүрээнд ТӨК үйлдвэрийн газруудын 122 байгааг 70 болгон цөөрүүлнэ. Ингэснээр урьдчилсан байдлаар нийт 26,7 тэрбум төгрөг хэмнэнэ.

6.Ноогдол ашгийн бодлогыг тодорхой болгоно. Цэвэр ашигтай ажиллаж байгаа боловч ноогдол ашиг төвлөрүүлдэггүй эсхүл ноогдол ашиг төвлөрүүлсэн ч урт хугацааны ноогдол ашгийн талаарх компани тус бүрийн онцлогт тохирсон бодлого тодорхойгүйгээс ашгийн хэмжээнээс үл хамаарч харилцан адилгүй хувь хэмжээгээр ноогдол ашиг хуваарилж байгаа нь компанид нэмэлт хөрөнгө оруулалт хийх, шинэ техник технологи, know how нэвтрүүлэх, үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зэрэг бизнесийн үйл ажиллагааг нь хязгаарлах нөхцөлийг бүрдүүлж байна. Иймд төрийн болон орон нутгийн өмчит компанийн ноогдол ашиг

хуваарилахад баримтлах зарчим, төсөвт төвлөрүүлэх хувь хэмжээг тооцох аргачлал зэргийг хуулиар тодорхой болгоно.

Хуулийн төсөлд ЗГ-ын байгууллагаас гадна Улсын Их Хурлын зарим харьяа байгууллага, аймаг, нийслэл, аймаг, нийслэлийн, дүүргийн ИТХ-ын дарга, Засаг дарга болон холбогдох хууль, хяналтын байгууллага, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагуудаас санал авч, олон нийтийн хэлэлцүүлгүүдийг үе шаттай зохион байгуулан хуулийн төсөлд тэдгээрийн саналуудыг тусгалаа.

Хуулийн төслийг баталснаар нийгэм, эдийн засаг, эрх зүйн хөгжилд чухал ач холбогдол бүхий бодлогын шинж чанартай дараах үр дагаврууд бий болно. Үүнд төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалын тогтолцоо сайжран, үйл ажиллагааны ил тод байдал, удирдлагын хяналт, үүрэг хариуцлага, ашигт ажиллагаа нэмэгдэнэ. Эдийн засгийн, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх чухал ач холбогдолтой томоохон төслийг хэрэгжүүлэх, хувийн хэвшилтэй тэгш нөхцөл, ижил дүрмээр аж ахуй эрхлэх замаар байгалийн баялгийг бий болгох, баялгийг оновчтойгоор дахин хуваарилах тогтолцоо бий болно. Иргэний хууль дахь хуулийн этгээдийн хэлбэрийг зөрчиж байгуулсан төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн статус тодорхой болно. Хувийн хэвшил гүйцэтгэх боломжтой төр заавал оролцох шаардлагагүй, зах зээлийн зарчмаар хөгжих боломжтой тодорхой салбарт төр хутгалдан орох, өрсөлдөөнийг хязгаарлах, алдагдал учруулах, бизнесийн эрсдэлийг, бизнесийн эрсдэлээс зайлсхийх боломж бүрдэнэ. Төр болон орон нутаг хувьцаа эзэмшигчийн эрхээ ил тод, шударга, хариуцлагатай, өрсөлдөөнд саад учруулахгүй хэрэгжүүлэх нөхцөлийг хэрэгжүүлнэ.

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт дагалдуулан боловсруулсан бусад хуулийн, хууль тогтоомжийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Р.Сэддорж:** Хуулийн төсөлд хийсэн хууль зүйн дүгнэлтийг Тамгын газрын тэргүүн дэд дарга Чойжилсүрэнгийн Ариунхур танилцуулна. Микрофоныг нээе.

**Ч.Ариунхур:** Эдийн засгийн байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Хууль зүйн дүгнэлтийг сонсоё. Монгол Улсын ЗГ-аас 2025 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмжийг нэмэгдүүлэх, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан бусад хууль, тогтоолын төслүүдийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн тул Улсын Их Хурлын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5.5, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 34.1 дэх хэсгийг тус тус үндэслэн энэхүү дүгнэлтийг гаргалаа.

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмжийг нэмэгдүүлэх, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл нь хамт өргөн мэдүүлсэн бусад хууль, тогтоолын төслүүдийн талаарх хууль зүйн дүгнэлтийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 34.1.1-ээс 34.1.6-д заасан асуудлын хүрээнд хууль зүйн дүгнэлтийг гаргасан болно.

Нэг.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуульд нийцсэн эсэх, хуулийн төслийн тодорхой зүйл, хэсэг, заалт хоорондоо зөрчилдсөн эсэх, тухайн төсөл, түүний зарим зүйл, заалт, хэсэг, заалтын зохицуулалтын хэсэг, заалтын зохицуулалт, хэрэгжих боломж, харилцан уялдааны талаар.

1.Компанийн тухай хууль нь өмчийн хэлбэр үл харгалзан бүх компанийн үйл ажиллагааг зохицуулах зорилго бүхий салбарын гол хууль учир компанийн эрх зүйн байдлыг төрийн эсвэл хувийн өмчөөр ялган зохицуулах нь хууль хэрэглээний нэгдмэл байдлыг алдагдуулахад хүргэх эрсдэлтэй. Иймд ТӨК байгуулах нийтлэг үндэслэлийг Компанийн тухай хуулиар зохицуулж, төр компани байгуулсан тухайн компаниа хэрхэн үр ашигтай ажиллуулах асуудлыг тусгайлсан хуулиар зохицуулж, төрийн өмчийн компанийн бүтээмж, засаглал, ил тод байдал, хариуцлагыг дээшлүүлэх хэм хэмжээг уг хуульдаа нарийвчлан тусгах боломжтой гэж үзлээ. Төслийн нэрийг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмжийг нэмэгдүүлэх, засаглалыг сайжруулах тухай хууль гэж томъёолсон хэдий ч төслийн 1.1-д энэ хуулийн зорилт нь төрийн болон орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулах үндэслэл, журмыг тогтоох, компанийн үйл ажиллагаанд баримтлах зарчим, удирдлага, зохион байгуулалт, хяналт, ил тод байдал, засаглалыг сайжруулах, бүтээмжийг нэмэгдүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино гэж зорилт, зохицуулах харилцааг төслийн нэрээс илүү өргөн хүрээнд тодорхойлсон байх тул төслийн зорилт, зохицуулах харилцаа, нэрийг уялдуулах нь зүйтэй байна.

2 төслийн 8 дугаар зүйлд төрийн болон орон нутгийн өмчит компанийг 5 үндэслэлээр үүсгэн байгуулахаар заасны дотор төслийн 8.1.1-д нийтийн зориулалттай дэд бүтэц, нийтийн үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулах үндэслэлээр төрийн өмчийн компанийг үүсгэн байгуулахаар тусгажээ. Мөн төслийн 8.2 дахь хэсэгт 8.1.1-д заасан үндэслэлээр компани байгуулахад хувийн хэвшил дангаараа гүйцэтгэх боломжгүй, зах зээлийн төвлөрөл өндөртэй байх нөхцөлийг хангасан байх гэдэг шаардлагыг тавих замаар төрийн өмчийн болон орон нутгийн өмчит компани байгуулах хүрээ хязгаарыг хумихаар заасан байна. 2002, 2022 онд батлагдсан Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулиар нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээний салбарт төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийг хэрэгжүүлэх, хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалтыг дэмжихтэй холбоотой харилцааг зохицуулж байна.

Уг хуульд тодорхойлсноор нийтийн зориулалттай дэд бүтэц гэдэгт олон нийтэд зориулсан зам, инженерийн шугам сүлжээ зэрэг иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах суурь нөхцөлийг бүрдүүлэх дэд бүтцийн байгууламж орох ба төрийн үйлчилгээ гэдэгт иргэдийн ая тухтай амьдрах таатай орчныг бүрдүүлэх зорилгоор төрөөс тодорхой салбарт иргэдэд тэгш, чанартай хэлбэрээр үзүүлж буй үйлчилгээг ойлгохоор заасан. Өөрөөр хэлбэл, дээрх дэд бүтэц, үйлчилгээг иргэдэд хүргэхэд төр тодорхой хэмжээгээр оролцох нь зайлшгүй боловч төр хувийн хэвшилтэйгээ өрсөлдөж, бүтээн байгуулалт хийдэг үйлчилгээ үзүүлдэг бус хувийн хэвшлийн оролцоог хангах, илүү чанартай бүтээн байгуулалтыг хувийн хэвшлээр хийлгэх үндсэн зорилгод нийцүүлэн түншлэл хэлбэрээр эдгээр үйл ажиллагааг явуулах өнөөгийн хуулийн зохицуулалттай төсөл хэрхэн уялдах нь тодорхой бус байна.

Төслийн 8.1.1 дэх заалт Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн үндсэн зорилттой зөрчилдөж, төр болон орон нутаг хувьцаа эзэмшигчийн эрхээ ил тод, шударга, хариуцлагатай өрсөлдөөнд саад учруулахгүй хэрэгжүүлэх, аж ахуй эрхлэгчийн зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх гэсэн төслийн үзэл баримтлалд тодорхойлсон шаардлагад харшилж байна гэж үзэхээр байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн хоёрт төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална. Мөн зүйлийн 4 дэх хэсэгт төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна. Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.3.2.5-д төрөөс стратегийн ач холбогдолтой эдийн засгийн салбар дахь зайлшгүй үйл ажиллагаанаас бусад бизнест оролцохыг хязгаарлаж, аж ахуйн шинжтэй чиг үүргүүдийг иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшлээр гүйцэлдүүлэх бодлого баримтална гэж заажээ. Төсөлд төрийн өмчийн компанийг үүсгэн байгуулахдаа хэлбэрийн хувьд тодорхой хязгаарлалт тавьж байгаа боловч Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 5.1.8, 5.1.13-д заасан нэр томъёоны тайлбарыг эшилсэн байдал, мөн төсөлд стратегийн ач холбогдолтой салбар гэдгийг хуулиар тусгайлан тодорхойлоогүйн улмаас 8.1.1-ээс 8.1.4 дэх заалт хэт өргөн хүрээг хамрахаар байна. Иймд төрийн болон орон нутгийн өмчийн компанийн эрх зүйн байдлыг тусгайлсан хуулиар зохицуулахдаа төрөөс аж ахуйн бүх хэвшлийн хөгжлийн зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулах Үндсэн хуулийн зарчмыг анхаарч үзэх шаардлагатай байна.

3.Төслийн 8.1.5-д хууль болон олон улсын хувийн эрх зүйн гэрээнд заасан үндэслэлээр төрийн өмчийн компанийг үүсгэн байгуулахаар, төслийн 3.3-д тухайлсан хуулийн дагуу байгуулагдсан төрийн өмчийн компанийн үйл ажиллагааг зохицуулна гэж зааснаас үзвэл төрийн өмчийн компанийг тодорхой хууль батлан гаргах замаар байгуулах боломжтой гэж ойлгож байна. Энэ зохицуулалтаараа тус хуулиас гадуур бусад хууль болон олон улсын хувийн эрх зүйн гэрээгээр төрийн өмчийн компанийг нэмж байгуулах асуудлыг нээлттэй болгож байна.

Төслийн дээрх зохицуулалттай холбоотой дараах асуудлыг нягталж үзэх нь зүйтэй байна. Төслийн 8.1.5 дахь заалт төрийн өмчийн компани байгуулах үндэслэлийг хязгааргүйгээр, харин илүү өргөн хүрээнд төрийн өмчийн компани байгуулах боломжийг бүрдүүлэх боломжийг олгосон зохицуулалт байна. Өөрөөр хэлбэл тусгайлсан хуулиар төрийн өмчийн компанийг байгуулахдаа тус хуулийн төслийн 8.1.1-ээс 8.1.4 дэх хэсэгт заасан үндэслэлээр байгуулах нь зохистой юм. Төслийн 8.5-д энэ хуульд зааснаас өөр үндэслэлээр төрийн болон орон нутгийн өмчийн компани үүсгэн байгуулахыг хориглоно гэж заасан хэдий ч 3.3, 8.1.5-д тухайлсан хууль гаргах замаар төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн компани байгуулахыг зөвшөөрсөн төслийн 8.1.1-ээс 8.1.4 дэх заалттай уялдах эсэхийг анхаарах. Төслийн 8.1.5 дахь заалт нь Улсын Их Хурал бүх ард түмнийг төлөөлөн төрийн өмчийн өмчлөгч байх суурь зохицуулалтад нийцэхгүй, өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр иргэний эрх зүйн гэрээгээр төрийн өмчийн компанийг үүсгэн байгуулах асуудлыг нээлттэй болгосон гэж үзэхээр байна. Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венын конвенц, Олон улсын гэрээний тухай хуульд зааснаар Монгол Улсын ЗГ-аас гадаадын хуулийн этгээд, иргэнтэй байгуулах олон улсын хувийн эрх зүйн гэрээгээр зохицуулагдах бизнесийн гэрээ хэлцэл нь олон

улсын гэрээнд тооцогддоггүй учир өмчлөгч хяналтаа хэрэгжүүлэх боломжийг хязгаарласан дээрх заалтыг төсөлд тусгах эсэхийг анхаарах шаардлагатай байна. Төслийн 3.3-д тухайлсан хуулийн дагуу байгуулагдсан гэдэгт тухайн хуулиуд эшлэх замаар хууль тогтоомжийн уялдааг сайжруулах шаардлагатай байна.

4.Компанийн тухай хуулийн 59.1.Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал /ХЭХ/ байна. 59.2.Нэг хувьцаа эзэмшигчтэй компанийн хувьд ХЭХ-ын бүрэн эрхийг хувьцаа эзэмшигч өөрөө хэрэгжүүлнэ гэж заасан. Гэтэл төслийн 22.2-т ХЭХ-ын бүрэн эрхийг энэ хуулийн 17.2, 17.5-д заасан этгээд хэрэгжүүлнэ. 17.2-т ТӨК-ийн төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийг ЗГ-ын шийдвэрээр тогтооно. 17.5-д орон нутгийн өмчит компанийн орон нутгийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга байна гэж тус тус заажээ. Дээрх зохицуулалт нь компанийн нийт гаргасан энгийн хувьцааг бүхэлд нь төр эсхүл орон нутаг дангаараа эзэмшдэг тохиолдолд хувьцаа эзэмшигчийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэх харилцааны хувьд ойлгомжтой мэт боловч компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 34-өөс 100 хүртэл хувийг төр эсхүл орон нутаг эзэмшиж байгаа нөхцөлд хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч этгээд нь ХЭХ-ын бүрэн эрхийг шууд хэрэгжүүлэхээр заасан нь Компанийн хуулийн дээрх зохицуулалт, компанийн засаглалын зарчимтай шууд зөрчилдөж, бусад хувьцаа эзэмшигчийн эрхийг зөрчихөөр байна. Иймд төслийн 22.2 дахь хэсгийн зохицуулалтыг илүү нарийвчилж, Компанийн тухай хуульд нийцүүлэн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн хувьд компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувь хэмжээтэй тэнцүүлэн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэгчийг тодорхойлж, түүнд бүрэн эрхийг нь зааж өгөх хэрэгтэй байна.

5.Төслийн 17.1-д хуульд өөрөөр заагаагүй ТӨК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигч нь ЗГ байна гэж, төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлд Компанийн тухай хуулийн 2.5, 2.6 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцохоор тусгасан. Тодруулбал Компанийн тухай хуулийн 2.5-д төрийн болон ОНӨҮГ-ыг компанийн хэлбэрт оруулан өөрчлөн зохион байгуулах замаар үүссэн төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагааг энэ хуулиар зохицуулна. 2.6.Энэ хуулийн 2.5-д заасны дагуу үүссэн ТӨК-ийн хувьд өмчлөгч нь төрийг төлөөлж Улсын Их Хурал, орон нутгийн өмчит компанийн хувьд тухайн орон нутгийн ИТХ байх бөгөөд тэдгээрийг төлөөлж хувьцаа эзэмшигч нь ЗГ болон орон нутгийн ИТХ-аас эрх олгосон этгээд байж болно гэж заасан.

Компанийн тухай хуулиар төрийн өмчийн компанийн хувьд өмчлөгч нь төрийг төлөөлж Улсын Их Хурал байсныг төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр хүчингүй болгохоор тусгасан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8.1.1-д Улсын Их Хурал бүх ард түмнийг төлөөлөн төрийн өмчийн өмчлөгч байх гэж заасантай зөрчилдөхөөр байна. Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8.1.1 дэх заалттай уг төслийн 17.1 дэх хэсэг болон хамт өргөн мэдүүлсэн Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлийг тус тус нийцүүлэх, эсхүл Компанийн тухай хуулийн одоогийн 2.6 дахь хэсгийн зохицуулалтыг тухайн хуульд хэвээр үлдэх шаардлагатай гэж үзэж байна.

Төслийн 37.4-д төрийн болон орон нутгийн өмчийн компани жил бүрийн санхүүгийн тайлангаа нягтлан шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа санхүүгийн баримтыг хянуулан хараат бус этгээдээр мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж гаргуулах зорилгоор хөндлөнгийн аудитын хуулийн этгээдийг үндсэн, үндсэн дээр аудит хийлгүүлнэ гэж, 37.5-д энэ хуулийн 37.4-д заасан хөндлөнгийн аудит хийх хуулийн этгээдийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан журмын дагуу аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдээс Төлөөлөн удирдах зөвлөл сонгон шалгаруулна гэж заасан болон төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай, Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөс үзэхэд төрийн өмчийн компанийн санхүүгийн тайланд аудит хийх эрх нь хөндлөнгийн аудитын байгууллагад шилжиж, төрийн аудитын байгууллагын чиг үүрэг хасагдахаар байна. Төрийн өмчийн компанийн санхүүгийн тайланд аудит хийх хөндлөнгийн аудитын байгууллагыг компанийн төлөөлөн удирдах зөвлөл сонгож байгаа бол төрийн аудитын байгууллага нь тус хөндлөнгийн аудитын байгууллагыг мэргэжил арга зүйгээр хангаж, явцын болон чанарын хяналтыг хариуцдаг гүйцэтгэх чиг үүргийг хэрэгжүүлдэг байхаар байна. Энэ чиглэлээр Төрийн аудитын тухай хууль болон Аудитын тухай хуулийг боловсронгуй болгож, холбогдох өөрчлөлтийг нэмж тусгах нь зүйтэй байна.

Түүнчлэн Төрийн аудитын тухай хуулийн 4.1.1-д төрийн санхүү, төсвийн хяналт гэж төрийн санхүү, төсөв, төсөв, хөтөлбөр, төсөл арга хэмжээ, эргэн төлөх нөхцөлөөр ашиглуулах үйл ажиллагаа, хувьчлах дуудлага худалдаа, техник эдийн засгийн үндэслэл, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа, зээллэг, гадаад тусламж, хандив, санхүүгийн дэмжлэг, өрийн баталгаа, үнэт цаас, бүх төрлийн гэрээ, хэлцэл болон бусад аливаа үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэлд ашиглалт, зарцуулалт, хэрэгжилт, тайлагналт, нийтийн өмчтэй холбоотой бүх үйл ажиллагаанд төрийн аудит хийхийг ойлгохоор нэр томъёоны тайлбарт хийсэн байна. Улсын Их Хурал хянан шалгах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу төрийн аудитын байгууллагын хууль тогтоомжид заасан чиг үүргийнх нь хүрээнд Улсын Их Хурал хяналт шалгалтад оролцуулахаар заасан тул төрийн аудитын байгууллага нь Улсын Их Хурлын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нэг байгууллага хэлбэр гэж үзэж байна.

Гэтэл төслийн 34, 37.4, 37.5-д заасан хэсэг болон энэ хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд зааснаас үзэхэд төрийн өмчийн компанийн санхүүгийн тайланд аудит хийх эрх нь хөндлөнгийн аудитын байгууллагад шилжиж, төрийн аудитын байгууллагын чиг үүргээс хасагдахаар байна. Ингэснээр Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт заасан Улсын Их Хурал бүх ард түмнийг төлөөлөн төрийн өмчийн өмчлөгч байх, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 4.2.2-т заасан ард түмний төлөөлөл болохын хувьд Улсын Их Хурал хянан шалгалтыг хэрэгжүүлэхдээ зөвхөн ард түмний нийтлэг ашгийг дээдлэн хамгаалах хуулиар хязгаарласнаас бусад тохиолдолд Улсын Их Хурал хянан шалгалтын явц, холбогдох мэдээлэл, үр дүнг олон нийтэд хүртээмжтэй, нээлттэй мэдээлэх зарчмуудтай зөрчилдөхөөр байна.

7.Төсөлд хууль зүйн техникийн шинжтэй дээр дараах асуудлыг анхаарч нягтлах нь зүйтэй байна. Төслийн 4.1.1-д ТӨК гэж төр нь энэ хуульд заасны дагуу хувьцааг нь эзэмшиж байгаа эсхүл хяналт хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийг ойлгоно гэж зааснаас үзэхэд төрийн өмчийн компани гэдэгт төр хувьцааг нь эзэмшиж байгаа аливаа компани хамаарахаар ойлгогдож байгаа боловч эсхүл хяналт хэрэгжүүлж байгаа хуулийн этгээд гэдэгт ямар этгээдийг хамруулах нь тодорхой бус байна. Төслийн 4.1.5-д нийтийн үйлчилгээ гэж Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 5.1.13-д заасныг ойлгохоор заасан боловч тус хуулийн 5.1.13-д нийтийн үйлчилгээ бус төрийн үйлчилгээ гэсэн нэр томъёог хуульчилжээ. Энэ нь нэг ойлголтыг нэг нэр томъёогоор илэрхийлэх Хууль тогтоомжийн тухай хуулийн шаардлагад нийцэхгүй байна. Төслийн 6 дугаар зүйлд төрийн болон орон нутгийн өмчийн компанийн ангиллыг заасан бөгөөд тус ангилалд 4.1.3-д заасан төрийн өмч давамгайлсан компани гэсэн ангилалд багтаагүй. Иймд тус ангиллаас гадуур өөр ойлголт төсөлд байх нь хууль хэрэглээ, хууль зүйн техникийн хувьд ойлгомжгүй байдал үүсэх тул төрийн өмчийн, төрийн өмч давамгайлсан компанитай холбогдох нэр томъёоны тайлбар, холбогдох тусгай зохицуулалтыг 6 дугаар зүйлд тэгш, тодорхой болгохыг зөвлөж байна. Төслийн 12.3-д танилцуулж шийдвэрлүүлэх үүрэгтэй гэснийг танилцуулж, энэ найруулгын шинжтэй ингээд цаашаа саналууд байна.

Төслийн 14.1-д Ашигт малтмалын тухай, Үндэсний баялгийн сангийн тухай хууль, Иргэний тухай хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Иргэний хууль, Компанийн хуулийг тус тус ерөнхий байдлаар эшилснийг өөрчилж, холбогдох зүйл, заалтыг тодорхой эшлэн оруулах, ТӨК-ийн, төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч хуульд зааснаас хуульд өөрөөр заагаагүй бол нэг этгээд байхаар заасан ба энэ эрхийг ямар байгууллага этгээд хэрэгжүүлэхийг тусгаагүй байна. Иймд төрийн өмчийн оролцоотой компанийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч, түүнчлэн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох төрийн өмчийн төлөөлөгч томилох асуудлыг тодорхой тусгахыг зөвлөж байна.

Төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9<sup>1.5</sup>, 9<sup>1.7</sup> дахь хэсэг болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд зааснаас үзэхэд төрийн өмчийн хяналтын улсын байцаагчийн орон тоо шинээр нэмэгдэхээр байгааг анхаарах, тус зохицуулалттай холбогдох хэсгийн үйлчлэлийг Төсвийн тухай хуулийн 6.2.5-д төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зардал нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх гэсэн заасантай нийцүүлэх нь зүйтэй байна. Түүнчлэн нийтийн үйлчилгээний байгууллага нь төсвийн хөрөнгөөр санхүүжихээр байхаар тул түүнтэй холбогдох зардлын тооцоо болон тухайн байгууллагын үйл ажиллагааны чиглэл зэрэг дэлгэрэнгүй танилцуулах мэдээлэл шаардлагатай байна.

Түүнчлэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 2024 оны 12 дугаар сарын 54 дүгээр тогтоолын 1.1-д бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн сахилга, хариуцлагыг дээшлүүлэх, тавих хяналтыг сайжруулах, төсөвт байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ачааллыг бууруулах, дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион



байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны дээд хязгаарт багтаан шийдвэрлэхийг ЗГ-т даалгасныг анхаарах нь зүйтэй байна.

Төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлд төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагыг ЗГ-ын тохируулагч агентлаг байхаар заасан боловч Улсын Их Хурлын 2024 оны 13 дугаар тогтоолоор баталсан уг тогтоолоор уг агентлаг нь хэрэгжүүлэгч агентлаг байгааг өөрчлөх тогтоолын төслийг хамт өргөн мэдүүлээгүй байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 13 дугаар зүйлд төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн эрхийн байдлаар 4 ангилалд хамааруулж байгаа бөгөөд Ашигт малтмалын тухай хуулийн 8.5 дахь хэсэгт төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой, орон нутгийн өмчит, орон нутгийн өмчит оролцоотой хуулийн этгээдийн эзэмшлийн хувь, эзэмшлийн хувьцаа, Монгол Улсын ЗГ-тай хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан хуулийн этгээдийн хувьцаанд энэ хуулийн 5.7 дахь хэсэг хамаарахгүй гэсэн нь төсөлд тусгагдсан төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанид хамаарахаар байгаа тул төрийн болон орон нутгийн өмчийн суурь харилцааг зохицуулсан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон энэ хуультай хамт, тухай хууль болон энэ хуулийн төсөлтэй нэг мөр нийцүүлэн Ашигт малтмалын тухай хуульд холбогдох өөрчлөлтийг оруулахаар байна.

Дүгнэлт, санал. Төслийн үндсэн хэсгийг Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиас шилжүүлэн авсан зохицуулалт бүрдүүлж байгаа бөгөөд тухайн хуулиудаас шилжүүлсэн холбогдох зохицуулалтыг хүчингүй болсонд тооцохоор тусгаснаар хууль хоорондын нийцлийг нэг мөр хангасан гэж үзэх боломжгүй байна. Иймд төслийн зохицуулалтыг Иргэний хууль, Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжтой уялдуулан сайжруулах, бусад холбогдох хуульд мөн төсөлтэй уялдуулах шаардлагын өөрчлөлтийг тусгах нь зүйтэй байна.

Түүнчлэн ЗГ-т чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын 2024 оны 52 дугаар тогтоолын 2.5-д Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн шинэчилсэн найруулгын болон Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын 2024 оны намрын чуулганы хугацаанд өргөн мэдүүлэхээр ЗГ-т даалгасныг анхаарах шаардлагатай байна. Төслийн зүйл, хэсэг, заалтыг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн сайжруулах, төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэх шатанд нэр томьёо, хууль зүйн техникийг хангуулах шаардлагатай байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Р.Сэддорж:** Байнгын хорооны хуралдаан түр завсарлая. Чуулганы нэгдсэн хуралдаандаа ороод.

*Хуралдаан 09 цаг 58 минутаас 10 цаг 10 минутад түр завсарлав.*

Ажлын хэсгийг танилцуулъя. Н.Учрал Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга, Д.Цолмон ЗГХЭГ-ын дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Б.Ганбат ЗГХЭГ-ын даргын зөвлөх, Б.Хулан ЗГХЭГ-

ын даргын зөвлөх, М.Цэлмүүн ЗГХЭГ-ын даргын зөвлөх, Д.Саруул ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Б.Цэнгэл ТӨБЗГ-ын дарга, Б.Төрбат ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын ахлах шинжээч, Б.Баяр-Эрдэнэ ТӨБЗГ-ын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга, Ц.Тэгшжаргал ҮСХ-ны Нэгдсэн статистикийн газрын дарга, Б.Гэрлээ Эрдэнэс Монгол компанийн Хууль, эрх зүйн зөвлөлийн дарга, О.Баярмагнай Эрдэнэс Монгол компанийн ерөнхий аудитор, Г.Давааням МУИС-ийн Хууль зүйн сургуулийн дэд профессор, Тэлмүүн, Жамъянхүү, Лхагвасүрэн ирээгүй байгаа юм байна.

Гишүүд орж ирж байна уу? Асуулт асуух гишүүдийн нэрс авна. Тийм учраас. Хуулийн төсөлд, төслийн талаар хууль санаачлагчаас асуулт асуух гишүүд нэрсээ өгье? Батшугар гишүүнээр тасалъя. Улсын Их Хурлын гишүүн Мөнхсоёл асуулт асууя.

**Б.Мөнхсоёл:** Өглөөний мэнд, сайн байцгаана уу? Сая олон асуултууд хариулт нь энэ хууль зүйн акт юу дүгнэлттэй нэлээн давхачихлаа. Маш сайн дүгнэлт уншсан. Тийм учраас аль болохоор давхцуулахгүй явъя гэж бодож байна. Яг энэ дүгнэлттэй миний хувьд санал нэг байгаа юм. Өөрөөр хэлбэл Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, өмчит компанийн тухай хууль, тэгээд Төсвийн хэмнэлтийн тухай хууль, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль гэх мэт хуулиудтай зарим заалтууд давхцаж байна. Ил тод, нээлттэй болгоно, засаглалыг сайжруулна гэсэн хэдий боловч зарим энэ зорилго зорилтууд нь хэрхэн амьдрал дээр хэрэгжих вэ гэдэг хангалттай заалтууд ороогүй байна гэж харсан.

3 дугаарт нь тухайн төрийн болон орон нутгийн өмчит компанийн нээлттэй байдлыг сайжруулна гэсэн боловч олон улсын жишээлбэл компаниуд хэрхэн энэ менежментэд оролцож, оролцох боломжтой ч вэ гэдэг юм уу, эсвэл 34 хувиас доош хувийн төрийн өмчит, төрийн оролцоотой байвал тухайн компанийг юу гэж үзэх вэ гэдэг ангилал нь ч юм уу байхгүй ийм тодорхойгүй зүйлүүд байх шиг байна. Энэ дээр тодруулж хариулт өгнө үү гэж хэлмээр байна.

Тэгээд түрүүн энэ дүгнэлттэй, дүгнэлтэд орсон нэг зүйлтэй санал нэг байгаа нь Үндэсний аудитын газар гэж байгаа шүү дээ. Үндэсний аудитын газрын гол зорилго нь Их Хурлын хяналт шалгалтын функцийг хэрэгжүүлэх ёстой. Гэтэл энэ дээр хөндлөнгийн аудит буюу төрийн аудитыг үгүйсгэсэн ийм заалт орж ирснийг санал нийлэхгүй байгаа. Тэгээд энэ Хууль зүйн хэлтсийн гаргасан дүгнэлттэй санал нэг байгаа юм. Энэ дээр холбогдуулаад хариулт хэлнэ үү гэж хүсэж байна. Тэгээд ерөнхийдөө нэлээн олон засах, залруулах олон зүйл байгаа. Энэ хууль зүйн дүгнэлт дээр ч дурдчихсан. Тэгээд эргэж харах шаардлагатай хууль юм уу гэдэг ийм санал байгаа давхар хэлчихье гэж бодож байна. Баярлалаа.

**Р.Сэддорж:** 5 номер хариулт Учрал Сайд.

**Н.Учрал:** Төрийн болон орон нутгийн өмчийн энэ компанийн бие даасан хуулийг яагаад гаргах шаардлагатай вэ гэвэл энэ бараг улсын төсөвтэйгөө дүйцэхүйц хэмжээний ийм томоохон бүтэц бий болчихлоо л доо. Тэгэхээр энэ яг зүгээр Мөнхсоёл гишүүнд хэлэхэд энэ нэг талаасаа нөгөө төрийн болон орон нутгийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг л энэ Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн хуулиар зохицуулна. Тэрнээс биш бусад

тэр хараат бус ТУЗ-ийн гишүүнийг томилох, чөлөөлөх, гүйцэтгэх удирдлагаа томилох, үйл ажиллагаатай холбогдсон бүхий л харилцаа Компанийн хуулиараа л зохицуулагдана. Энэ нэг талаасаа өөрөө нөгөө нийтийн эрх зүйн хуулийн этгээд. Ер нь төрийн өмч л гэж нэрлээд байгаа болохоос энэ бол эцсийн өмчлөгч нь ард түмэн шүү дээ.

Тэгэхээр энэ ард түмний өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлж байгаа гэдэг утгаараа зайлшгүй нийтийн эрх зүйн хуулийн этгээд гэдэг утгаараа жишээ нь ТУЗ-д төрийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрхэн хэрэгжүүлэх юм бэ гэдгийг асар тодорхой болгохгүй бол компани өөрөө бие дааж засаглах ерөөсөө ямар ч нөхцөл бололцоогүй болсон байхгүй юу. Яагаад тэгэхээр Засгийн газар жишээ нь хувьцаа эзэмшигч гэж үзэхээр компани бизнес төлөвлөгөөгөө гаргаад үйл ажиллагаа явуулж байхад ЗГ шийдвэр гаргаад л бизнес төлөвлөгөөнд нь өөрчлөлт ордог, төлөвлөгөөнд тусгагдаагүй ажлуудыг санхүүжүүлдэг, ингээд ашигт ажиллагаа нь буурдаг. Тэгэхээр бид цаашдаа ТӨК-удын ашигт ажиллагааг нэмэгдүүлэх чиглэл рүү ажиллая гэвэл нэгтгэх, өөрчлөх, зохион байгуулах, татан буулгах, нээлттэй болгох чиглэлээр энэ хуулийг батлан гаргасны дараа ЗГ төрийн өмчийн компаниуд дээр ямар бодлого баримтлах юм, аль салбарт орох юм, аль салбарт орохгүй юм, алийг нь нээлттэй болгох юм, алийг нь татан буулгаж, нэгтгэж, өөрчилж зохион байгуулах юм бэ гэдгээ шийдвэрлэдэг ийм зөв механизм руу энэ OECD-н зарчмыг бариад орж байгаа юм.

Тийм учраас энэ хуулийн төслийг боловсруулахад энэ OECD зарчмыг бүрэн барьсан. Дээрээс нь нөгөө EBRD-с зөвлөх үйлчилгээ өнгөрсөн хугацаанд олон ЗГ-ын үед аваад, өнөөдөр яг энэ хууль болоод орж ирж байгаа юм. Тийм учраас энэ хууль батлагдан гарснаараа түрүүн мэдээлэл дээр уншсан. Эхний байдлаар бид шууд цалингийн зардал дээр 26,7 тэрбум төгрөгийг хэмнэнэ. Статус ойлгомжтой болно. Хууль батлагдан гарснаар ТӨХ-нд бүртгэлтэй 122 компани бол толгой компани 56, охин компанитайгаа нийлээд 70 компани болтлоо буурна. Ингэж чадвал та бүхэн харсан 380 тэрбум төгрөгийг 50 гаруй компани нийлээд бүрдүүлдэг байсан. Энэ байсан 5-хан компани нийлээд 4,7 их наядыг бүрдүүлээд, 41 компани ашиггүй ажиллаад байхад ашигтай ажиллаж байгаа нь ч адилхан цалинтай, ашиггүй ажиллаж байгаа нь ч адилхан цалинтай. Тэгээд гүйцэтгэлийн үнэлгээ гэж юм байхгүй. ТУЗ-ийн гишүүний тавигдах шаардлагууд нь ойлгомжгүй, гүйцэтгэх удирдлага хэрхэн гэрээ хэлцлийг сунгах нь ч тодорхойгүй ингээд яваад байх юм бол цаашдаа бид тийм тодорхой дэвшил гаргаж чадахгүй юм байна лээ.

Тийм учраас бид ийм бие даасан хуулийг гаргаад, цаашлаад энэ уул уурхайн компаниудаа Эрдэнэс Монгол, уул уурхайн бусуудаа Эрчист Монгол гээд энэ давхардсан чиг үүргийг бууруулах чиглэлээр тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр Монгол Улсын ЗГ ажиллаж байгаа. Тийм учраас бие даасан хуулиар зохицуулахгүйгээр зүгээр Компанийн хуулиараа яв гээд орхих юм бол ард түмний өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх дээр ийм ил тод, нээлттэй байлгах дээр асуудал цаашдаа шийдэгдэхгүй. Зүгээр ил тод, нээлттэй байдал дээр бид энэ хууль батлагдсанаар 74 мэдээлэл ил болж байгаа. Нөгөө цалин хөлс, урамшуулал бүх зүйлийг ил болгоно. Одоо бол Шилэн дансны хуулиар, Нийтийн мэдээллийн хуулиар 50 гаруй мэдээлэл ил байгаа шүү дээ. Тэгэхээр энэ бол 74 хүртлээ нээлттэй болохоор засаглал сайжирч таарна.

Тэр аудит дээр олон улсын аудит, хөндлөнгийн аудит гэдэг ойлголтууд бий. ТУЗ-ийн дэргэд 2 тэрбум төгрөгөөс борлуулалтаас дээш орлоготой байвал 3-аас доошгүй хүнтэй ийм аудит ажиллаж.../минут дуусав/

**Р.Сэддорж:** 5 номер гүйцэтгэж хариульъя Учрал сайд.

**Н.Учрал:** Тэгэхээр энэ дотоод аудит бол ТУЗ-ийн дэргэд ажиллана. Мэдээж нөгөө төрийн аудит чиг үүргийнхээ хүрээнд ажиллаж байгаа шүү дээ. Бид 2023 оны Үндэсний аудитын байгууллагын тайланд үндэслээд л энэ статистикуудыг ярьж байгаа л даа. Тэгэхээр дотоод аудит бол ТУЗ-ийн дэргэд үйл ажиллагааг сайжруулах чиглэл рүү ажиллаж байгаа. Тэгэхдээ энэ дээр бүх компани дээр аудит ажиллана гэдэг ойлголт байхгүй. Энэ дээр босгууд тавьсан юм, тэр 2 тэрбум төгрөг. Дээрээс нь 75-аас дээш хүнтэй бол 3 хүртэлх тооны аудит байна ч гэдэг юм уу ингэж хатуу зааж өгч хөндлөнгийн аудитыг нь оруулж ажиллах нөхцөлийг хангаж байж энэ цаашдаа хөндлөнгийн, хараат бус байдлаар ажиллах бололцоо бүрдэнэ. Тэгээд энэ аудит дээр нэмэлтээр ажлын хэсгээс хариулах байх.

**Р.Сэддорж:** 9 номер уу? 9 номер хариулт.

**О.Баярмагнай:** Баярлалаа. Ажлын хэсгийн гишүүн Баярмагнай байна. Энэ дотоод аудит буюу энэ Компанийн тухай хууль дээр хяналтын тогтолцоо гээд 6 дугаар бүлэг дээр ийм том шинэ ийм бүлэг орж ирсэн. Энэ бүлэг Компанийн тухай хуулиасаа илүү онцлогтой. Гишүүн та юу яахын 37.13 дахь заалт дээр байж байгаа. Компанийн тухай хууль дээр байхгүйгээс илүүтэйгээр өөрөөр хэлбэл дотоод аудитын хараат бус байдлыг нь ТУЗ буюу компанийнх нь ТУЗ, түүний хажууд байгуулагдаж байгаа мэргэжлийн аудитын хороо хараат бус байдлыг нь хангаж өгнө гэж байгаа. Энэ заалтаар юу илэрхийлж байна вэ гэхээрээ дотоод аудитын үйл ажиллагааг ямар нэгэн хөндлөнгийн оролцоогүйгээр, хараат бусаар үр дүн гаргах ийм боломжууд нээгдэж байгаа гэсэн үг.

Өөрөөр хэлбэл төрийн болон төрийн бус байгууллага ямар нэгэн төрийн болон хүн гэдэг юм уу этгээдийн оролцоогүйгээр аудит хийх боломж өөрөө нээгдэж байгаа. Үүгээрээ та бүхэн анзаарч байгаа бол яг юу гэдэг юм нэг жилийн 2023 оны дата баримт дээр.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Мөнхсоёл гишүүн тодруулж асууна.

**Б.Мөнхсоёл:** Хариулт өгсөнд баярлалаа. Тэгээд ерөнхийдөө би товчхон хэлье. Хууль зүйн энэ дүгнэлттэй санал нийлэхгүй байгаа гэж ойлгох уу? Миний асууснаас илүү маш олон том дүгнэлтүүд хэлсэн байна. Би гүйцээн боловсруулах ийм саналтай байгаа юм буцаагаад. Магадгүй хууль тусдаа, зорилт зорилго тодорхой шүү дээ. Бид маш олон жил шүүмжилсэн төрийн өмчит үйлдвэрийн газрууд болон төрийн өмчит компаниуд маш олон жил алдагдалтай ажилласан, цөөхөн тавхан хэдхэн нь ашигтай Эрдэнэтээс өгсүүлээд. Тэгэхээр энэ дээр яаж ч байсан засаглалыг сайжруулах, ил тод байдлыг хангах, ашигт ажиллагааг нэмэх энэ асуудал буюу зорилго бид битгий хэл гадаа байгаа иргэдэд хүртэл ойлгомжтой байгаа шүү дээ. Бидний, миний асууж байгаа асуулт яаж хэрхэн шийдэх вэ гэдэг чинь энэ хуулиар тодорхой орж ирээгүй асуудалтай байна. Энийг би биш, зөвхөн би биш, энэ хууль зүйн дүгнэлт чинь батлаад байна, бүр олон асуудлаар баталсан байна. Тэгэхээр гүйцээн боловсруулах шаардлагатай гэдгийг хэлмээр байгаа.

**Р.Сэддорж:** 5 номер хариулъя. Учрал сайд.

**Н.Учрал:** Энэ хуулийн төсөл бол энэ хамтарсан ЗГ-ын үед өргөн баригдаад байгаа болохоос биш өнгөрсөн хугацаанд энэ үе үеийн ЗГ-ын үед л боловсруулагдаж байсан. Энэ OECD-н зарчмаар л бичигдсэн ийм хууль л даа. Энэ хуулийг гаргахгүй бол цэгцлэх ийм эрх зүйн орчин бүрэн бүрдэхгүй байгаа юм. Энэ шалгуур, шаардлагуудыг өндөр тавихгүй бол энэ улс төрийн нөлөөлөл байсаар байна. Энийг шийдээд явахад үнэхээр бэрхшээлтэй. Энийг хуулиар хатуу заахгүй бол болохгүй байна гэдэг зорилгоор л энэ хууль бичигдсэн.

Хууль зүйн дүгнэлтийг би өглөө сонслоо. Тийм. Энэ өглөө сонссон учраас би одоо сайн танилцахгүй байна, танилцаагүй байна. Манай энэ ажлын хэсэг бол яг энэ EBRD, TBI гээд олон улсын зөвлөхүүд, хуулийн багийнхан хамтарч боловсруулсан. Тэгэхээр энэ зөвлөгөөг би өглөө сонссон. Тэгээд Их Хурал дээр ажлын хэсэг байгуулагдаад, энэ Тамгын газрын саналуудыг тусгаад ингээд хаврын чуулган хүртэл ажиллах бололцоо байгаа байх гэж бодож байна.

**Р.Сэддорж:** Асуулт дээр Энхтүвшин гишүүн, Мандхай гишүүн нарыг нэмье. Ренчиндоржийн Батболд гишүүн асуулт.

**Р.Батболд:** Өглөөний мэнд та бүхэнд. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах хууль орж ирж байгаа нь сайн байна. Энийг дэмжээд байгаа юм. Тэгээд энэ дээр яах вэ нөгөө өчигдөр бид Байнгын хорооны даргын өрөөнд ажлын хэсгийнхэнтэй жоохон суусан. Ганц нэг асуух зүйл байгаад байсан юм. Энэ нөгөө орон нутгийн өмчтэй уул уурхайн компаниуд дээрээ асуудал үүсээд байх вий дээ тэрийг яаж зохицуулах вэ гэдэг асуудлыг л би нэг тодруулаад асуучихмаар байгаад байгаа юм. Тэгээд энэ хууль зүйн дүгнэлт сая Учрал даргын хэлж байгаагаар хууль зүйн дүгнэлтийг өглөө сая л харлаа л даа. Энд нэлээн их нийцүүлэх зүйл байгаад байх шиг байна. Энийг уншиж байгаад нийцүүлэх тал дээр нь ажиллах юм уу, эсхүл яг өөрсдийнхөө төслөөрөө тэр чигтээ явах гээд байна уу? Энийг хариулж өгөөч.

**Р.Сэддорж:** 5 номер Учрал сайд.

**Н.Учрал:** Ер нь бид Үндэсний баялгийн сангийн хуулийг батлан гаргасан. Тэгээд баялгийн сан бол орлого төвлөрүүлж байгаа уул уурхайн компаниудынхаа төрийн өмчийн компаниудынхаа 34 хувийг эзэмшээд, тэр ноогдол ашиг нь хуримтлалын санд хуримтлагддаг. Тэгэхээр одоо бол энэ статус асар их ойлгомжгүй байгаа юм. Улсын төсөвт үйлдвэрийн газар гээд нэг байгууллага байдаг төсвөөс санхүүждэг. Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гээд нэг гараараа болохоор орлого ол гэдэг, нөгөө гараараа болохоор төрийн үйлчилгээ явуул гээд байдаг. Тэгээд зарим нь ТӨК гээд нэртэй мөртөө зарим компани дээр төр 10, 15 хувийг эзэмшиж байгаа тохиолдол ч байдаг л юм байна. Тэгээд ТӨК-уд нь 3 жил дараалаад санхүүгийн алдагдалтай ажиллачихсан байхад авч байгаа цалин, унаж байгаа машин, бүх амьдрал хэв хэвээрээ үргэлжилсээр л байдаг. Тэгээд энэ шударга бус л даа.

Тэгээд нөгөө нэг баялгийн санд 270 тэрбум төгрөг бүрдүүлж байгаа, төвлөрүүлж байгаа Эрдэнэт үйлдвэрийн ТУЗ-ийн гишүүн, захирал, удирдлага яг л адилхан цалинтай, санхүүгийн алдагдалтай ажиллаж байгаа компани адилхан л цалинтай. Ашигт ажиллагаа, ашигт ажиллагаа нь сайжирсан ч гэсэн тэр нөгөө

гүйцэтгэлийн үнэлгээнд суурилоод урамшуулах механизм ч тодорхой биш, ил тод биш. Тэгэхээр ийм байдлаар цаашаа явахгүй нь л дээ. Тэгээд бид энэ статусыг цэгцэлье гэж байгаа юм. Ер нь энэ олон улсад энэ public institution гээд байгаа энэ нийтийн үйлчилгээний байгууллага гээд ер нь энэ ТӨК-аас гаргах шаардлагатай, төрийн үйлчилгээ явуулж байгаа байгууллагуудыг ТӨК-аас гаргаад, ТӨК бол дотроо ашигтай ажиллах ёстой гэдэг үндсэн шалгуур тавина.

2-т мэдээж төрийн чиг үүргийг биелүүлэх тэр үнэ тарифын зохицуулалттай холбоотой, жишээ нь эрчим хүчний салбар ч гэдэг юм уу энэ тухайлан авч үзэх асуудал. Ингээд ялгана. Уул уурхайн компаниуд дээр нэг ийм 4 аймаг дээр л ийм уул уурхай орон нутгийн өмчийн компани байгаа юм байна лээ. Энийг энэ аймаг орон нутгуудын статусыг хэрхэн зохион байгуулах вэ гэдгийг ажлын хэсгийн түвшинд бид ярилцаад, шийдээд явчхаж болох байх гэж бодож байна. Зүгээр Их Хурал дээр ажлын хэсэг байгуулагдаад бид нэлээн ийм хугацаа авч байгаа нь юу вэ гэхээр энэ чуулганы завсарлагааны хугацаанд ТӨК-ынхаа засаглалыг сайжруулах чиглэлээр уулзалтууд хийе. их хурлын гишүүдийнхээ ажлын хэсэгтэйгээ бид ЗГ хамтарч ажиллая. Тэгээд мэргэжлийн экспертүүд энэ дэд ажлын хэсэгт ажилласан баг бүрэлдэхүүн Их Хурлын гишүүдтэйгээ хамтарч ажиллая. Ингээд угаасаа Их Хурлын ажлын хэсэг хуулийн төсөл дээр ажлын хэсэг өөрсдийнхөө саналыг гаргаад ажиллах бүрэн бололцоо байгаа. Тийм учраас үзэл баримтлал алдагдуулахгүйгээр энэ хуулийн төсөл дээрх яаж ажиллах нь мэдээж Их Хурлын бүрэн эрх. Тийм учраас Их Хурлын ажлын хэсэг дээр энийг ярилцаад, шийдвэрлээд явчхаж болох байх гэж бодож байна.

**Р.Сэддорж:** Батболд гишүүн тодруулна.

**Р.Батболд:** Тодруулах гэхээсээ илүү нөгөө орон нутагтаа хувьцаа гаргаад нэг уул уурхайн компани явуулчих ч юм уу нэг тиймэрхүү орон нутгийн иргэддээ хувьцаа гаргах ч юм уу. Тэгэхээр тэрийг төрийнх гэж ойлгох юм уу, юу гэж ойлгох юм бэ гэдэг л нэг асуудал л үүсээд байгаа юм. Зүгээр би тэгж хараад байгаа юм наадхыг чинь. Орон нутгийн өмчит гэхээр яах вэ одоо бид ойлгоод байна шүү дээ. Төсвөөс цалинждаг ч юм уу, нэг аж ахуйн тооцоотой ч юм уу ийм газрууд байгаад байдаг. Тэрийгээ бид орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд гэж яриад байна шүү дээ. Гэтэл орон нутгийн иргэддээ хувьцаа гаргаад явж байгааг юу гэж ойлгох вэ? Орон нутаг гэж яаж явах юм бэ л гэдэг нэг асуудал гараад байна гэж хараад байгаа юм наана чинь. Төрийн өмч гэхээсээ илүү орон нутгийн иргэдэд хувьцаа гаргасныг яг яаж салгаж ойлгох бол?

**Р.Сэддорж:** 4 номер хариулт, танилцуулаад.

**Б.Цэнгэл:** Тэгэхээр өнөөдрийн хувьд Өвөрхангай аймгийн Баянтээх, Өмнөговьд жижиг Тавантолгой, Хөвсгөлд Могойнгол, Сэлэнгэд Мандалхишиг хайрхан гээд ийм 4 уул уурхайн чиглэлийн үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд байж байгаа юм. Ер нь энэ хуулиар бид орон нутгийн өөрөө удирдах ёс руу ер нь нэг их халдсан юм байхгүй гэж ойлгож байгаа. Зөвхөн төрийн болон төрийн өмчийн оролцоотой компаниудын зохицуулалтыг оруулж ирж байгаа юм. Тэгэхээр таны яриад байгаа асуудал яг гол агуулгаараа Үндсэн хуулийн 6.2 луу яваад орчхож байгаа юм. Уул уурхайн баялгийн үр өгөөжийг нийт иргэд хүртэнэ. Энэ асуудал нь Улсын Их Хурлын бүрэн эрхэд байх юм. Баялгийн сангаараа дамжуулна гэдэг агуулгаараа төрийнхөн ч бай, орон нутгийнхан ч бай ингээд

цаашдаа Үндсэн хуулийн 6.2-ынхоо зарчмаар явна гэж бид ойлгож байгаа. Гэхдээ яг үйл.../минут дуусав/

**Р.Сэддорж:** 4 номер гүйцээгээд хариулъя.

**Б.Цэнгэл:** Үйл ажиллагаа явж байгаа орон нутгийн иргэдийн нутгийн өөрөө удирдах ёс ИТХ-ын бүрэн эрхэд хамаарч байгаа энэ орон нутаг нь 51 хувь эзэмшиж байгаа энэ компанийн хувьд үйл ажиллагаанд нь оролцоод байх ийм юм байхгүй. Энэ бол одоо зохицуулагдаж байгаа эрх зүйн харилцаагаараа явна. Зүгээр том зургаараа Үндсэн хуулийн 6.2-оороо цаашаа зохицуулагдаад явах ийм л харилцаа байгаа юм. Баярлалаа.

**Р.Сэддорж:** Бадамсүрэн. Хариулт хангалтгүй гэж үзэж байна. Батболд гишүүн.

**Р.Батболд:** Би тодруулчихъя. Өчигдөр тэгж ярьсан юм. Үндсэн хуулийн 6.2 луу гээд. Тэгээд энэ чинь нөгөө дахиад орон нутагтаа, орон нутгийн өмчтэй ийм компаниудыг орон нутгийн иргэд нь хувьцаа эзэмшсэн компаниудыг байгуулахад аягүй хэцүү болчих байх л даа. Тэгээд 6.2-оор гэхээр бүгдээрэнг нь нөгөө нааш нь төвлөрүүлж авчирч байгаад, эргүүлээд орон нутагт нь хуваарилдаг энэ тэр гээд юмнууд үүсээд эхэлнэ. Тэгээд нөгөө орон нутгийн иргэд чинь энэ уул уурхайг чинь дахиад дэмжээд явах юм уу, явахгүй юм уу? Ийм л асуудал үүсэх байх л гэж бодоод байна.

**Р.Сэддорж:** 5 Номер Учрал сайд.

**Н.Учрал:** Хууль батлагдсаны дараа бид нөгөө ЗГ-аас ТӨК-уд дээр баримтлах үндсэн чиглэлийг Их Хурлаар оруулна. Тэр оруулах үедээ Их Хурлын тогтоолоор нөгөө аль компанийг нээлттэй болгох юм, аль компанийг нэгтгэх юм, өөрчлөх юм, зохион байгуулах юм, ер нь ямар, ямар салбарт илүү фокус хийх юм бэ гэдгээ ЗГ өөрөө баримтлах чиглэлээрээ оруулж ирэх юм. Ер нь Их Хурлын тогтоолоор бид нээлттэй компани болох тогтоол баталдаг байсан шүү дээ. Өмнө нь парламент ч тэр. Тэгэхээр одоо баримтлах чиглэлээ гаргаж ирэхдээ энэ орон нутгийн өмчит компаниудыг яаж үйл ажиллагаа явуулах юм бэ гэдгийг онцгойлон авч үзээд л Их Хурлын тогтоолоор оруулаад шийдчихэж болох болов уу гэж ингэж бодож байгаа. Тэгэхээр юу гэдэг юм нутгийн өөрөө удирдах байгууллага өөрөө шийдвэрээ гаргаад, Засаг дарга нь хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлээд компани байгуулах нь нутгийн өөрөө удирдах байгууллагын асуудал. Гэхдээ энэ дээр 34-өөс багагүй хувь эзэмшихгүй, 34-өөс дээш л эзэмшинэ гэдэг ийм л ялгаа байгаа. Тэгээд л байгуулаад явж болох байлгүй.

**Р.Сэддорж:** Энхцэцэг гишүүн асуулт асууна. Бадамсүрэн гишүүнийг асуулт дээр нэмье.

**М.Энхцэцэг:** Сайн байцгаана уу, та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Энэ хуультай холбоотойгоор Эрдэнэс Монгол гээд компани дээр нэмээд Эрчист Монгол гээд энэ компанийг шинээр бий болгох гэж байгаа юм байна. Тэгээд уурхайн компаниуд нь Эрдэнэс Монголд харьяалагдаад, уурхайн бус ТӨК-уд нь Эрчист Монгол компанид харьяалагдана гэсэн ийм асуудлыг ярьж байна. Тэгэхээр энэтэй холбоотой хэд хэдэн асуулт байна. Эрдэнэс Монгол компанийг анх яг ямар зорилготой байгуулсан юм бэ? Яг энэ компани чинь яг та бүхний тэр зорилгод

хүрэх хэмжээнд ажилласан юм уу? Бодвол энэ компанийг та бүхний яриад байгаа тэр бүтээмжийг нь уул уурхайн компаниудын бүтээмжийг нь, тэр засаглалыг нь, энэ бүх л юмнуудыг нь сайжруулах зорилготой л байгуулсан байлгүй. Тэгэхээр энэ компанийн үйл ажиллагаанд нь та бүхний тэр анхны тавьж байсан зорилгод хүрсэн эсэхэд тийм үнэлгээ хийсэн асуудал байна уу?

Яагаад гэхээр энэ Эрдэнэс Монгол компанийн доор байгаа уул уурхайн компаниуд энэ Эрдэнэс Монгол компанийн үйл ажиллагаанд маш сэтгэл хангалуун бус байдаг гэж ойлгосон. Яагаад гэвэл маш олон саналууд ирж байна. Тухайлбал ингээд үйл ажиллагаа, үйлчилгээ үзүүлдэг гэдгээр доод компаниудаа уул уурхайн компаниудаасаа маш их хэмжээний төлбөр авдаг, үйлчилгээний хөлс авдаг. Тэгэхээр яг чухам ямар үйлчилгээ үзүүлж байгаа нь тодорхой бус, ямар тусламж үйлчилгээ үзүүлж байгаа нь тодорхой бус. Тэгээд тэр маш их хэмжээний төлбөрийг ямар хуулийн үндэслэл дээр хурааж авдаг нь тодорхойгүй энэ тэр гээд гээд маш олон сэтгэл хангалуун бус ийм үнэлгээнүүд ирж байна л даа. Тэгэхээр өөрөөр хэлбэл энэ Эрдэнэс Монголынхоо үйл ажиллагаанд үнэлгээ хийж байж, дараагийнхаа компанийг байгуулах асуудлаа ярьдаггүй юм уу?

Эрчист Монгол гээд дахиад төрийн бус, төрийн өмчит бусад компаниудыг харьяалуулна гэж байна. Тэгэхээр энэтэй холбоотойгоор жишээ нь энэ маань 1 дүгээрт хар даа ийм асуудал ... байгаа байхгүй юу. Нөгөө төрийг данхар бүтэцтэй бий болгож байгаа юм биш үү? Дарга компанийг дахиад бий болгож байгаа юм биш үү? Бодвол ингээд эрчим хүчний бүхий л ТӨК-уд дахиад дээр нь дахиад нэг ийм Эрчим хүчний яамнаас гадна дахиад нэг ийм дарга компани бий болох гээд байна л даа Эрчист Монгол гээд. Тэгэнгүүт нөгөө уул уурхайн энэ эрчим хүчний компаниудын хариуцлага нь 1 дүгээрт ингээд суларчихна. Тэгээд нэг ийм үйлчилгээний хөлс гээд хэдэн тэрбум төгрөгийг жилдээ тушаадаг ийм бий болох гэж байгаа юм байна уу гэж энэ дээр ингээд асуулт асуумаар байна.

Дараагийн нэг асуудал болохоор ер нь аливаа компанид мэдээж ингээд олон асуудал байдаг. Бүтэмж, энэ бүтээмж болон энэ засаглал гэдэг тэр олон асуудлын зөвхөн 2 л асуудал. Тэгэхээр ингээд асуудал болгон дээр ингээд тусгайлан хууль гараад байх юм уу гэдэг ийм асуултыг асууя.

**Р.Сэддорж:** Хариулт 5 номер Учрал сайд.

**Н.Учрал:** Эрдэнэс Монгол нэгдэл бол Үндэсний баялгийн сангийн хуулийг өнгөрсөн парламентад баталснаар статус болоод хүлээх үүрэг асар тодорхой болсон. Үндэсний баялгийн сангийн хуулиар Эрдэнэс Монгол бол баялгийн сангийн орлогыг төвлөрүүлж байгаа хуулийн этгээд. Нэг ёсондоо төрийн өмчит уул уурхайн компаниудынхаа ашиг орлогыг иргэний хуримтлалын данс руу шилжүүлж байгаа юм. Үүний тусламжтайгаар сая тэр 480 тэрбум төгрөг баялгийн санд төвлөрөөд, үүнийг нь бид иргэний хуримтлалын данс буюу иргэн болгон дээр харагддаг цаашдаа үүнийхээ орлогыг нэмэгдүүлэх бололцоог бүрдүүлэх чиглэлээр үйл ажиллагааг нь явуулсан.

Ингээд Эрдэнэс Монгол бол яг олон улсын жишгийн дагуу ийм холдингийн зарчмаар ажиллаж байгаа. Холдингийн зарчмаар. Тэгээд энэ Эрдэнэс Монгол чинь анх яг статус нь тодорхойгүй, яг л таны хэлдгээр 10 жилийн өмнө энэ чинь зүгээр нэг ийм толгой компани юм байна, юу хийдэг нь ойлгомжгүй юм байна гээд л хүмүүс шүүмжилдэг байсан. Одоо ингэж ярьж болохооргүй болсон юм билээ.



Яагаад гэхээр би тэр дүгнэлтүүдтэй нь ч танилцсан. ТУЗ чинь бараг энэ чинь 3 дахин ТУЗ-ийг нь бууруулаад, нэгтгээд давхардсан чиг үүргүүдийг арилгасан шүү дээ. Тэгээд одоо 31 хуулийн этгээд л байгаа байхгүй юу Эрдэнэс Монгол дээр. Энэ тоо чинь бараг 60 гаруй юм байна лээ шүү дээ. Тэгэхээр энэ чинь ингээд нэгдсэнээрээ давхардсан чиг үүргүүд арилаад, яагаад тэр уул уурхайн компаниудын орлогыг тэнд төвлөрүүлээд ингээд авч байгаа вэ гэхээр тэр Эрдэнэс Монгол хурааж аваад байгаа биш байхгүй юу. Тэр юу вэ гэхээр Үндэсний баялгийн сангийн орлогыг бүрдүүлж байгаа юм хуультай. Үндэсний баялгийн сангийн хуулиар тэгээд зохицуулагдсан юм. Тэрнээс биш тэгж зүгээр тэндээс тийм татаас аваад байгаадаа биш.

Дээрээс нь Эрдэнэс Монгол байгуулагдсанаараа энэ олон улсын, олон энэ мега төсөл хэлэлцээрүүдийг явуулахад Эрдэнэс Монгол компанийн баг бүрэлдэхүүн хамгийн сайн баг болж ажиллаж байгаа. Жишээ нь сая тэр нөгөө Оранотай байгуулах энэ хөрөнгө оруулалтын гэрээ дээр гэхэд л Эрдэнэс Монгол компани л яг энэ хэлэлцээр, ажлын хэсэг, бүх үйл ажиллагааг мэргэжил арга зүйн чиглэлээр нь ажиллаж, олон улсын түвшинд хэлэлцээр хийж чадаж байгаа. Энэ бол олон улсын сайн жишиг мөн.

Тэгэхээр уул уурхайн бус компаниудыг яг Эрдэнэс Монголын сайн жишгийн дагуу ажиллуулъя л гэж байгаа юм. Эрчист Монгол гээд. Тэрнээс энэ нэг компани байгуулаад байгаадаа ерөөсөө биш. Жишээ нь Эрчист Монгол компани гээд байгуулагдаад байна гэж шууд хэлж болохгүй. Энэ бол давхардсан чиг үүргүүдийг нийлүүлээд, ерөөсөө тэр бусад уул уурхайн бус компаниуд дээрээ компаниудынхаа үйл ажиллагааг тэр төрийн өмчийн корпорацтай уялдуулаад, яг тэр жишээ нь Сингапурын тэр Temasek holdings гэдэг холдинг чинь болохоор ерөөсөө л салбар салбаруудыг нэгтгээд л ийм холдингийн зарчмаар л ажиллуулсан. Тэгээд энэ олон улсын сайн жишиг. Яг түүн шиг ажиллана. Тэгэхээр жишээ нь Эрчист Монгол байгуулагдсанаараа ТУЗ-ийн тоо 31, гишүүдийн тоо 279, ТУЗ-ийн нарийн бичиг 31 хүнээр шууд цөөрнө. Ингээд зарим захирал, нэгжийн даргын давхардлууд арилаад эхлэхээр 11 тэрбум төгрөгийг шууд хэмнэнэ. Жишээ нь share service буюу тэр хэвлэл, олон нийт, хууль эрх зүй, аж ахуй, хүний нөөц ч гэж гэдэг юм уу, гадаад харилцаа ч гэдэг юм уу ийм давхардсан чиг үүргүүд компани болгон дээр байх шаардлагагүй болоод эхлэхээр сервисээ шэйрлэж эхэлнэ. Оновчилно гэсэн үг.

Тэрнээс энэ нэг компани байгуулаад байгаа бол огт биш шүү. Тэгэхээр үүний тусламжтайгаар Эрдэнэс Монголын дэргэд 4 групп байдаг. Зэс, металл, логистик гээд гэдэг шиг Эрчист Монголын дэргэд эрчим хүч, банк санхүү, зам тээвэр, барилга ч гэдэг юм уу 4 салбарын нэгдэлд л хуваагдаж байна. Тэгэхээр тэр олон ТУЗ огт хэрэггүй байхгүй юу, группийн зарчим руугаа орно. Ингэж байж цаашдаа ашигт ажиллагаа нэмэгдэнэ гэж тооцож байгаа юм.

**Р.Сэддорж:** Энхцэцэг гишүүн тодруулна.

**М.Энхцэцэг:** Тэгэхээр энэ дээр яах вэ би нөгөө түрүүн асуусан. Ерөнхийдөө нөгөө тухайн компанийн хариуцлагын асуудал суларч байгаа юм биш юм уу? Ер нь л яах вэ зүгээр эрчим хүчний компаниуд бүгдээрээ захиргаа удирдлагын хэлтэсгүй, хуулийн хэлтэсгүй бүх юугүй болоод энэ компани л удирдах юм байна. Тэгэхээр нөгөө нэг хуучин эрчим хүчний салбар ийм босоо бүтэцтэй буюу босоо удирдлагатай байсан. Тэгэхээр энэ босоо удирдлага руу шууд бараг л Эрчим

хүчний удирдах газар гээд хуучин байсан яг түүн шиг тийм юуны бүтэц нь энэ Эрчист Монгол дээр ирээд ийм буцаад нөгөө бид ухралт руугаа орж байгаа юм байна гэсэн ийм юу харагдаад байна л даа. Ингээд төрийн, эрчим хүчний 18 компани байдаг. Тэгэхээр 18 компани нь тэр дээр тэртээ тэргүй Эрчист Монгол нь мэдэж байгаа юм чинь гээд үүрэг хариуцлага нь яаж ч бодсон ер нь хэн ч бодсон тийм сулрахаар юм байна л даа. Тэгэхээр ингээд жаахан тийм л санагдаж байна л даа. Энэ дээр хариулт өгөөч. Тэгээд нөгөө ер нь аливаа асуудал аливаа компани олон асуудлуудтай. Тэгэхээр энэ бүтээмж, засаглал гэдэг 2 хоёрхон л асуудал. Тэгэхээр энэ асуудал болгон дээр.../минут дуусав/

**Р.Сэддорж:** 5 номер Учрал сайд.

**Н.Учрал:** Та шууд тэгж ойлгож болохгүй. Энэ share service гээд байгаа чинь юу юм бэ гэхээр жишээ нь хуулийн хэлтэс зарим ТӨК дээр 10 хүнтэй хуулийн хэлтэс байна. Хэрвээ Эрчист Монгол дээрээ ингээд холдингийн зарчмаар ажиллавал Эрчист Монгол дээрээ жишээ нь 10 хүн хуулийн хэлтэст ажиллаж байхад тус компани хуулийн 1 л хүнтэй байхад болох байхгүй юу. Олон нийттэй харилцах хэлтэс гээд дээрээ үнэхээр байгаа бол, гадаад харилцааны хэлтэс групп дээр нь 10 хүн байгаа бол тухайн охин компани дээр заавал гадаад харилцаа хариуцах хүн байх шаардлагагүй байхгүй юу. Тэрнээс биш бүх газар, хэлтсийг нь зөвхөн нэг компани дээр удирдаад ингээд явна гэж юм байхгүй шүү дээ. Энэ чинь share service гэдэг чинь зарим сервисээ шэйрлэхээр ийм бид тооцоо гаргаад энэ 122-ыг яаж 70 болгож бууруулах вэ гэдэг тооцоолол яриад байна л даа. Жишээ нь мэдээллийн технологийн хэлтэс гэхэд бүх охин компани дээр байх хэрэгтэй юм уу? 10 хүнтэй бол толгой компани дээрээ хариуцаж байгаа бол 10 хүнтэй толгой компани бусад нь 1 хүн.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Учрал сайд гүйцээж хариулья.

**Н.Учрал:** Тэгэхээр тэгэхээр ийм нөгөө сервисээ шэйрлэх, давхардсан чиг үүргүүдийг арилгаад, оновчлох зорилгоор л энэ Эрчист Монгол гэж хийж байгаа. Дээрээс нь бид ер нь цаашдаа энэ Эрчист Монголын активын юуг нь өндөр болгоод, олон улсад гаргах чиглэл рүү л, нээлттэй компани болох чиглэл рүү л ажиллана. Нэг ёсондоо тэр компаниудынхаа үр ашгийг нэмэгдүүлээд, Эрчист Монгол гэдэг тэр холдинг нь өөрөө актив их өндөртэй болгож чадвал бид олон улсад нээлттэй компани болгон хөрөнгө мөнгө босгох чиглэл рүү орно. Эрчим хүчний компани тэр алдагдалтай 43-ын 20-г нь эзлээд байгаа юм. Тэгэхээр бид чиг үүргээ оновчлох үйл ажиллагаа зохион байгуулахгүй бол болохгүй. Тэгээд энэ ер нь мэдээж энэ төрийн өмчийн компаниудыг цэгцлэх ажилд олон нийтийн дэмжлэг маш их чухал. Тэрнээс биш 58 мянган хүн ажиллаж байгаа учраас энэ хүмүүс чинь өөрсдийнхөө эрх ашгийг ярьдаг л даа. Тийм учраас хэдүүлээ нэг зоригтой хамт сууж байгаад асуудлыг.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Пүрэвжавын Сайнзориг гишүүн.

**П.Сайнзориг:** Хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж байгаа. Ажлын хэсэг гараад, сайтар ажиллаад сайжруулах зүйлүүд дээр нь ярилцаад, гишүүдийн ярьж хэлэлцэж байгаа зүйлүүдийг тусгаад явах боломжтой гэж харж байгаа. Ер нь энэ асуудал нэлээн хууль зүйн нюанстай асуудлууд байгаа. Уг нь манай Эдийн засгийн байнгын хороо мэргэжлийн байнгын хороо уг нь ХЗБХ-тойгоо яг энэ хууль дээр уг

нь өмчийн эрх зүй талаас нь хамт суучихмаар байгаад байгаа. Энийг яах вэ зүгээр Байнгын хорооны дарга бодно биз.

Тэгээд би яах вэ зүгээр энэ Улсын Их Хурлын Тамгын газрын гаргаж байгаа хууль зүйн дүгнэлтийг өглөө авлаа. Өглөө ч биш сая авлаа. Зарим зүйлүүдийг нь авах, гээхийн ухаанаар хандаж болно. Тэгэхдээ үнэхээр харамсаж байна. Би энэ Баасандорж дарга, Ариунхур дарга, Дондогмаа даргад ямар хүмүүс доор нь ажиллаж өгөөд байна вэ? Үнэхээр зарим талаараа бүр ингээд гутарч байна шүү. Өнөөдөр эрх зүйн салбараа ялгахгүйгээр ийм дүгнэлт бичиж байна шүү дээ. Өнөөдөр ТӨК-ийн ЗГ талаасаа юм уу, төр талаасаа процедурыг уг нь бусад оронд хууль гаргахгүйгээр заавар зааварчилгаа guidelines-р явдаг юм. Манайд энэ байгаа юм, биелүүлэхгүй байгаа байхгүй юу. Тийм учраас энийг хуульчилж байгаа. Энэ хэсгийг захиргааны эрх зүй гэдэг юм. Би энэ дүгнэлт бичиж байгаа хүнд хэлье. Компанийн хуулийг хувийн эрх зүй гэдэг юм. 2 ийм эрх зүйг хольж болдоггүй юм.

Тэгэнгүүтээ энэ дээр ингээд биччихсэн байгаа байхгүй юу. Компанийн хууль төрийн болон хувийн өмчөөр нь ялгаж зохицуулах хуулийн нэгдмэл байдлыг алдагдуулна гээд. Тэгээд Компанийн хуулиараа явуул дур дураараа л компани байгуулдаг юм хэвээрээ л явна шүү дээ. 2 дугаарт Компанийн хууль дээр ЗГ-ын процедурыг бичиж болдоггүй байхгүй юу даа. Та нар яагаад ингэж харалган ийм дүгнэлт гаргаж, яг ярьж байгаагийнхаа эсрэг ийм дүгнэлтийг гаргаж ингээд гишүүдэд ийм нэг ийм сонин байдалтай оруулж байгаа юм. Тэгээд би энэ дээр Баасандорж даргад жоохон хариуцлагатай байя гэж хэлмээр байна. Тэгээд нэг ийм баахан ийм үл ойлголцлын баахан олон хуудастай цаас шидчихдэг. Ямар ч эрх зүйн салбар эрх зүйн ойлголтгүй хүмүүс ингээд биччихсэн. Энэ тэгээд яг юу болоод байгаа юм бэ? Тэгээд энийг нь нэг их гишүүд ингээд л ёстой супер юм болчихож гээд. Биш шүү. Энд эрх зүй мэддэг, онол ном мэддэг, энийг цэгцэлье гэж байгаа хүмүүсийн бүр яг эсрэгээр нь бичсэн байна. Тэгэхээр би нэг ийм юм хэлэх гээд байгаа юм. Тэгэхээр яах вэ гишүүд энийг наанатай, цаанатай хандаарай гэж хэлэх гээд байгаа байхгүй юу.

2 дугаарт энэ дээр би дахиад хэлье. Олон улсын хувийн эрх зүйн гэрээ гэдэг бол Оюун толгойн гэрээ, сая Ораногийн гэрээ. Үүгээр компани байгуулж болох байхгүй юу. Энэ нэг үндэслэл нь байж байхад энэ үндэслэл нь биш байна гээд биччихэж байгаа юм. Тэгээд яг ямар үндэслэлүүдийг яах гэж байгаа юм. Хуультай ТӨК байдаг Хөгжлийн банкнаас эхлээд. Энэ бол компанийг байгуулахыг задгай тавьж байна гээд дүгнэлт бичиж байгаа байхгүй юу. Улсын Их Хурлын хяналтад байна гэдэг чинь задгай тавьж байгаа хэрэг биш гэх зэргээрээ энэ дээр ингээд дүгнэлтүүд нь яг ярьж байгаа юмныхаа эсрэг байгаа юм. Тэгээд 2 дугаарт би хамгийн чухал юмнууд нь тэр техникийн юмнуудыг нь авч болно. Энэ хууль буюу салбар эрх зүйг битгий холиоч.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Сайнзориг гишүүнд 1 минут.

**П.Сайнзориг:** Салбар эрх зүйг ингээд хольсноороо болоод энэ нөгөө нэг мөрдөгдөх зарчим аль шүүхийн хяналт нь байх вэ гэдэг нь бүх юм ингээд учир дутагдалтай болчихдог байхгүй юу даа. Энийг маань ойлгоод өгөөч. Тэгээд ингээд ЗГ-ын процедурыг заавал Компанийн хууль бичих ёстой гээд ийм юм яриад сууж байгаа хууль зүйн дүгнэлт гэдэг парламент шүү, парламентын экспертийн алба энийг гаргасан гэж бодож байгаа юм. Харамсаж байна. Тэгээд энийгээ бичсэн хүн нь зүгээр онигоо шүү би зүгээр хэлчихье. Тэгээд Баасандорж дарга ийм юман

дээрээ анхаараарай, орж ирээд суух ёстой шүү дээ. Нэг ийм болсон, болоогүй өглөө 8 хуудас юм биччихээд ийм сонин юм ингээд гишүүдийн дунд нэг үл ойлголцол гаргадаг. Тэгээд би энэ дээрээ анхаараач гэдэг зүйлийг Улсын Их Хурлын Тамгын газарт хандаж хэлж байгаа юм. Энэ дээр орж ирж байгаа ЗГ-ын байр суурийг сонсьё. Энэ салбар эрх зүйнүүдийг ингээд холоод хийж болох юм уу эсвэл тэр МУИС-ийн багш хариулаач. Ийм төрлийн хуулиуд манайд явж байгаа учраас энэ салбар, хүндрэлтэй байхгүй юу. Энэ Авто тээврийн хууль ингээд батлагдчихсан юм. Энэ Иргэний нисэхийн хууль ингээд батлагдчихсан юм.

**Р.Сэддорж:** Хариулт 2 номер.

**Г.Давааням:** МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш Давааням хариулъя. Би 2 зүйл дээр төвлөрье гэж бодож байна. Нэгд нь нөгөө Компанийн хуулиас тусдаа хууль яагаад тэгээд Компанийн хууль дээрээ тусгах ёстой байсан гэдэг ийм агуулга байгаа. Тэгэхээр сая Сайнзориг гишүүний хэлсэнчлэн өөрөөр хэлбэл зарим энэ төрийн өмчийн тусгай харилцааг Компанийн хууль дээр тусгах ийм боломжгүй зүйлүүд байгаад байгаа. Компанийн хууль гэдэг нийтлэг компанид зориулсан үүсгэн байгуулах гэхэд чөлөөтэйгөөр ийм, ийм процессоор үүсгэн байгуулна гэдэг юм. Төрийн өмчийн хуулийг үүсгэн байгуулах илүүтэйгээр ТӨК-ийг ийм, ийм үндэслэлээр байгуулна шүү гэдгийг хязгаарлахад, тэгээд тэрийг өөрөө тэр хууль дээрээ аваачих нь зохимжгүй ч гэдэг юм уу. Тэгэхээр өөрөөр хэлбэл энэ хуулийг тийш нь аваачиж холих нь зохисгүй. Ийм байж байгаа.

2 дахь нь болохоор зэрэг энэ төрийн өмчтэй холбоотой энэ харилцаа дээр ингээд журам гаргаад л өнөө хүртэл явсан. Тэгээд журам нь өөрчлөгдөөд л тогтворгүй байдлаар ингээд төрийн дотоод нэг хувьцаа эзэмшигч хувьцаа, эзэмшигчийн эрх хэрэгжүүлэгчтэй холбоотой ийм харилцаа байгаад байгаа. Тэгээд тэрийг нийтлэг нөгөө нэг аж ахуйн хэлбэрүүдэд үйлчилдэг Компанийн хууль дээр ингээд тусгайлаад аваачаад зохицуулах нь эрх зүйн системчлэлийн хувьд асуудлыг давуулахаар ингээд харагдаж байгаа. Тэгэхээр бусад дүгнэлтүүдийн хувьд нөгөө нарийн та танилцаагүй болохоор хэлэх боломжгүй байна. Тэгэхээр Компанийн хуультай уялдаа холбооны хувьд тийм зөрчил гэх юм уу юунууд байхгүй болов уу гэж миний хувьд хараад байгаа. Баярлалаа.

**Р.Сэддорж:** Сайнзориг гишүүн хариулт хангалтгүй гэж үзэж байна, тодруулъя.

**П.Сайнзориг:** Тэгэхээр би энэ дүгнэлтээс ингээд авч, гээхийн ухаанаар хандаасай. Авчихмаар зүйлүүд байна лээ. Тэгэхдээ энэ хамгийн том суурь дүгнэлтүүд нь ингээд буруу чиглэлдээ явчхаад байгаа байхгүй юу. Яг энэ хуулийн гарах үндэслэлүүдийн эсрэг дураараа компани байгуулж болох асуудал. Хэрэв Компанийн хууль дээр нийтлэг байдлаар зохицуулах юм бол энэ үндэслэл дарамтууд нь хувийн хэвшилд бизнес хийх орчныг нь хумьж өгнө гэсэн үг. Тэгэхээр ийм хольж болохгүй харилцаануудыг хольж хийх ёстой гэдэг дүгнэлт гаргаж болохгүй гэдэг зүйлийг би Улсын Их Хурлын Тамгын газарт хэлмээр байгаа юм.

2 дугаарт яах вэ зүгээр энэ ТӨК-удын асуудлыг цэгцэлбэл Монгол дахь энэ авлигыг цэгцлэх юм. Тэгээд энэ дээр нөгөө ажилчид нь хяналт тавьдаг, захиран зарцуулах эрхгүйгээр тодорхой тооны хувьцааг ажилчдад эзэмшүүлдэг ийм хувилбаруудыг ажлын хэсэг ер нь юу гэж бодож байгаа вэ? Дээрээс нь яах вэ зүгээр нэг зүйл байна. Тодорхой хэмжээнд энэ төсвийн бодлоготойгоо уялдуулж

байгаа. Урьд нь ингээд ЗГ-аас тогтоол гаргаад л энэ төслийг санхүүжүүл гэгчидэг байсан. Тэгэхээр ер нь зүгээр энэ.../минут дуусав/

**Р.Сэддорж:** 2 асуултад хариулт, 5 номер Учрал сайд.

**Н.Учрал:** Төрийн өмчийн биш хувийн энгийн компаниуд бол ажилчдадаа хувьцаа хуваарилдаг, гүйцэтгэлийг нь өөрөөр үнэлдэг ийм механизмууд байдаг. Гэхдээ төрийн өмчийн компани дээр энэ адил биш л дээ. Яагаад гэхээр энэ нийтийн өмч, ард түмний өмч гэдэг утгаараа ажилчдад шууд хувьцаа хуваарилах тийм боломж байхгүй юм байна лээ. Харин энэ баялгийн сангийн хувьд яг энэ хуулиараа зохицуулагдаад уул уурхайн компаниуд явж байгаа. Уул уурхайн бус компаниуд дээр хэрвээ ашигт ажиллагаа нь нэмэгдээд, яг энэ холдингийнхоо зарчмаар ажиллаад, ашигт ажиллагаа нь нэмэгдээд эхэлсний дараа иргэдэд хувьцаа хүртээх, хувьцаа эзэмшүүлэх чиглэлээр санаачилга гаргаж болох байх. Одоо бол тэгэхдээ мэдээж цаг нь биш байна л гэж бодож байна.

**Р.Сэддорж:** Баярлалаа. Хариулт Төсвийн бодлоготой яаж уялдах гэж байна гэдэг тал дээр. 6 номер.

**Д.Цолмон:** ЗГХЭГ Цолмон. Сайнзориг гишүүний асуултад нэмэлтээр хариулъя. Төрийн болон орон нутгийн яг энэ өмчит компаниудын ашигт ажиллагааны үр дүнд бий болж байгаа ноогдол ашиг бол улсын төсвийн орлогын бүрэлдэхүүн хэсэг байдаг. Тэгэхээр яг энэ асуудалтай холбоотойгоор тусгайлсан зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан байгаа. Ноогдол ашгийн бодлого. Энэ ноогдол ашгийн бодлогыг баримтлах ер нь Компанийн хуулиараа ноогдол ашгийн бодлогыг ТУЗ өөрөө баталдаг. Тэгэхээр төрийн болон орон нутгийн өмчит энэ компаниудын хувьд ноогдол ашгийн бодлогыг энэ хуулиараа арга замыг нь нээж өгөөд, 2 аргачлалаар тооцоод, 2 аргачлалаар тооцсон хамгийн их дүнгээр нь улсын тухайн жилийн улсын төсөвт тусгах энэ зохицуулалт ороод ирсэн байгаа.

Хэрвээ тухайн компани нь тухайн жилдээ ноогдол ашиг хуваарилах боломжгүй, үйл ажиллагааны тодорхой шалтгаанаар боломжгүй гэж үзэж байгаа тохиолдолд энэ үндэслэлээ хувьцаа эзэмшигч, эрх хэрэгжүүлэгчдээ мэдэгдээд, Улсын Их Хурал болон.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Батшугар гишүүн асуулт асууна.

**Э.Батшугар:** Баярлалаа. Энэ Төрийн өмчийн компанийн тухай хуулиудыг харахад олон улсын жишгүүд байгаа. Яах вэ хамгийн сайн жишиг гэдэг нь 1 дүгээрт Сингапурын жишиг байдаг. 2-т нь Норвегийн жишиг байгаа. Мөн Шинэ Зеландын Төрийн өмчийн тухай компанийн тухай хууль 1989 онд батлагдсан хууль байгаа юм. Үүнтэй холбоотойгоор нэмж хэлэхэд яг Английн ХК-удын хууль нэлээн сайндаа тооцогддог. Монголд хэрэгжиж байгаа хамгийн сайн засаглал болон ил тод байдлын тухай компанийн засаглал бол юунд банкнууд байгаа юм. Ялангуяа хувьцаат компани болчихсон, бирж дээр гарчихсан банкнууд бол хамгийн ил тод, хамгийн сайн засаглалтай. Дээрээс нь нэмээд бүх тайлангуудаа улирлаар нь, жилээр нь тавьдаг.

Үүнтэй холбоотойгоор хэд хэдэн асуулт байна. 1 дүгээр асуулт нь энэ ТУЗ-ийн хараат бус гишүүний энэ 24.6-д байна. Энийг 50 хувь болгож болох уу гэж асууя. Мөн хуулийн 16.1.1-д аудит хийлгэсэн тайлангаа вэбсайт дээрээ жил болгон

заавал байлгах тавих ёстой гэдэг тийм заалт оруулж бололцоотой байна уу? Мөн манай Монголын арилжааны банкнуудад байдаг энэ ТУЗ-ийн доор хараат бус аудитын хороо гэж байдаг. Тэгэхдээ үүнтэй холбоотойгоор нэг заалтууд зүгээр юм уу гэж бодох юм. Ашигт ажиллагаагаа яг ямар параметруудээр тавих вэ? Ялангуяа энэ тал дээр 5.1.2-т тодорхой заамаар байгаа юм. Нэлээн тийм бөөрөнхийлчихсэн заалтууд байна. Мөн онолоороо бол natural monopoly гэж ярьдаг л даа. Энэ төрийн зохицуулалттай компаниуд ялангуяа эрчим хүч, дулаан, мөн бусад зайлшгүй ард иргэд болон нийтэд хэрэгтэй гэхдээ заавал ашигт ажиллагаатай ажиллах тийм зохимжгүй компаниуд байдаг. Энэ дээр ямар байдлаар хандаж байгаа вэ? Ялангуяа эрчим хүч бид үнийг нь төрөөс зохицуулдаг юм мөртөө ашигтай ажил гээд байж болохгүй шүү дээ асууя.

Хариуцлагын хувьд 5.1.1-д тодорхой хэмжээгээр тавьсан байна. Ил тод, нээлттэй байх зарчимтай. Тэгэхдээ энийгээ илүү сайжруулах бололцоо байна уу? Ялангуяа би түрүүн хэлсэн. Санхүүгийн тайлангаа тогтмол өөрийнхөө вэбсайтаараа тавьж байх. Худалдан авалтаа ч гэсэн яах вэ мэдээж тендерээр явж байгаа. Гэхдээ яг ямар компани худалдан авалтад оролцож байна энэ маш ил тод баймаар байгаа юм. Яагаад гэвэл түрүүн ч гэсэн гишүүд хэлж байна. Энэ худалдан авалт дээр хамгийн том шүүмжлэл ирдэг.

**Р.Сэддорж:** Хариулт 5 номер, Учрал сайд.

**Н.Учрал:** Батшугар гишүүний асуултад хариулъя. Энэ ТУЗ дээр 1/3-ээс дээш нь гишүүд нь хараат бус гишүүд, 1/3-ээс доошгүй нь төрийн төлөөлөл гээд явж байгаа. Нэг ёсондоо энэ босгуудыг бол жишээ нь төрийн төлөөлөл нь 1/3-ээс дээшгүй шүү гээд хараат бус нь 3-аас дээш буюу 3-аас багагүй байна гэж. Тэгэхээр хэд ч байх боломжтой, энийг нэмэгдүүлэх ёстой. Энэ нь мэдээж ТУЗ-ийн гишүүдийг нээлттэй сонгон шалгаруулалтаар сонгохыг нь тэр бүх процессыг нь хуульд тусгасан, ил тод, нээлттэй байна. Тэр нийт 74 мэдээлэл ил болох дотор санхүүгийн тайлан болон санхүүгийн бус бүх мэдээлэл нь ил байна. Үүнд тэр тендерийн худалдан авах ажиллагааны мэдээллүүд ил тод байна. Тэгээд мэдээж аудитын тайланг ил тод байлгана. Жил бүрийн тайланг ил олон нийтэд нээлттэйгээр байршуулах үүрэгтэй төрийн өмчийн компаниуд. Гол зүйл нь юу вэ гэхээр төрийн өмчийн компанийн гүйцэтгэх удирдлага гэрээ байгуулахдаа гэрээндээ мэдээллийг ил болгох үүргийг гэрээгээр хүлээж байгаа. Тэгэхээр гэрээ сунгахгүй байх үндэслэл нь өөрөө энэ олон нийтэд мэдээллийг ил болгохгүй байгаа асуудал.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуулиар 68 мэдээлэл ил болгосон ч гэсэн үүрэг хариуцлага оновчтой байгаагүй учраас ТӨК-уддаа жишээ нь өмнөх парламентын үед би цахимын сайд байхдаа нэлээн үзсэн шүү дээ. Тэд чинь мэдээллийг ерөөсөө ил болгодоггүй юм байна лээ. Яагаад гэвэл манай хуульд бичигдээгүй шүү дээ. Наад Нийтийн мэдээллийн хуулийг чинь бид яаж дагах юм гээд ингээд байдаг. Тэгээд сая төсөв дагуулсан Төрийн өмчийн хуулиар ч ил тод байдлыг хуульчиллаа. Энэ хуулиар ч гэсэн нэмж байна. Ингээд ер нь ТӨК-ийн бүх мэдээлэл ил тод нээлттэй болно.

Ашигт ажиллагаа ашиггүй ажиллаж байгаа байдал дээр жишээ нь ер нь энэ хууль гарснаараа ТӨК-ийг ямар тохиолдолд байгуулах юм бэ гэдэг нь хатуу хуульчилчихаж байгаа юм. Жишээ нь нийтийн үйлчилгээ, нийтийн зориулалттай дэд бүтэц гээд хуульчилчихсаны хүрээнд нийтийн үйлчилгээний чиглэлээр үйл

ажиллагаа явуулж байгаа зарим компаниуд ашиггүй ажиллаж байгаа. Гэхдээ төр заавал тэр тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэгтэй. Энэ утгаараа ашиггүй ажиллаж байгаа мэдээллээ мэдээлээд явна. Гэхдээ нэг хариуцлага байгаа. Ямар нэгэн байдлаар санхүүгийн алдагдлыг бууруулж байх ёстой. Гэтэл 3 жил санхүүгийн алдагдлыг огт бууруулаагүй, ингээд дандаа алдагдалтай, дахиад огт алдагдлыг бууруулаагүй байгаа бол сая төсөв дагасан ТӨК-ийн Төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн компанийн хуулиар татан буулгах үндэслэл болж байгаа.

Тэгэхээр бид ашиггүй ажиллаж байгаа зарим тэр үнэ тарифын зохицуулалттай холбоотой зарим салбарууд дээр ашиггүй ажиллаж байгаа үндэслэлүүдээ мэдээлээд, үүнээс гадна авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд, нөгөө алдагдлыг бууруулж байгаа төлөвлөгөө юмнуудаа ТУЗ-дөө оруулаад, нээлттэй хэлэлцээд ингээд явна гэж ойлгох ёстой. Тийм учраас бид цаашдаа олон салбарт тийм үйл ажиллагаа ТӨК явуулахгүй. Тэр 5 чиглэлээс өөр салбарт огт үйл ажиллагаа явуулахаас татгалзаж байгаа. Жишээ нь сая АЗЗА дээр энэ 20 компани нэгдээд, яг энэ давхардсан чиг үүрэг оновчлох ажлууд одоо хийгдэж байна л даа. Тэгээд энэ АЗЗА дээр гэхэд жишээ нь зам хариуцахаа төр хариуцаад, зам арчилгаагаа хувийн хэвшлийн аутсорсингоор хийлгэж болж байгаа байхгүй юу. Зарим чиг үүрэг. Тэрнээс зам хариуцах нь төр байхгүй бол арчлахыг нь ч, хариуцахыг нь ч хувьд өгчихөөр нөгөө ашиггүй ажиллаад эхлэхээрээ орхиод явчихдаг талтай хувийн хэвшил бас зарим ийм үйл ажиллагаа. Ялангуяа нөгөө дүүргүүдийн хогон дээр ч гэдэг юм уу. Тэгэхээр энэ дээр зарим чиг үүргээ шилжүүлээд, яг хариуцах чиг үүргээ төр авч үлдэх ийм онцгой нийтийн үйлчилгээний салбарууд байна.

**Р.Сэддорж:** 2 номер үргэлжлүүлж хариулъя.

**Г.Давааням:** Батшугар гишүүний Аудитын хороотой холбоотой асуулт дээр нэмэлтээр хариулъя. 9 гишүүнтэй төрийн болон орон нутгийн өмчит ТУЗ 9 гишүүний бүрэлдэхүүн бүхий ТУЗ-тэй төрийн болон орон нутгийн өмчит компани дээр ХК-тай адилхан засаглалын загвараар буюу ТУЗ-ийн дэргэд нэр дэвшүүлэх цалин урамшууллын аудитын 3 хороог заавал байгуулахаар. Түүнээс доошоо гишүүнтэй байх юм бол аудитын хороог заавал байгуулахаар. Бусад хороодын хувьд сайн дурын шинжтэйгээр компаниас харгалзаад байгуулахаар ийм байдлаар зохицуулсан байгаа хуулийн төсөлд. Баярлалаа.

**Р.Сэддорж:** Энхбаяр гишүүн асуулт асууна.

**Б.Энхбаяр:** Би бол энэ Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалыг сайжруулах хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг дэмжиж байгаа. Энэ 2016 онд ЗГ-ын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт орж, сүүлийн 8 жилийн турш 2 удаагийн парламент дамнаж яригдсан том хүлээгдэж байгаа, тулгамдсан шийдвэрлэвэл зохих асуудлын тэргүүн эгнээнд байгаа ийм асуудал байгаа. Сүүлийн 2 удаагийн парламент хамгийн их сонсгол хийж, хулгай юмнууд төрийн өмчийн компаниуд дээр байгаа тухай олонтоо ярьсан. Энэ удаагийн парламент ч гэсэн ярих юм шиг байна. Тэр нь ч их тодорхой харагдаж байна.

Үе үеийн засгийн газрууд, үе үеийн парламентуудын эрх ашиг, зөрчил, улс төр, талцал хуваагдал, авлига, шунал, бүгд баялагт хэн эзэн байх вэ гэдэг энэ шуналын сэдлээс үүдэж гарч ирдэг. Улсын Их Хурал буюу ард түмний төлөөллийн

дээд байгууллага дээр өмчийн эзэн гэсэн Үндсэн хуулийн үг үсэг хэрэг дээрээ лоозон болж хувирсан. Бид бие даасан хувийн өмчийн компанийн харилцааг зохицуулж байгаа хуулиар төрийн буюу нийтийн эрх ашгийг төлөөлөх төрийн өмчийн компаниудын харилцааг зохицуулснаас үүдэлтэйгээр тэр хувийн өмчийн компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлагууд, өмчийн эзэд ард түмний хяналтаас бүрэн гарсан, Улсын Их Хурлын хяналтаас бүрэн гарсан. Хамгийн их хулгай зэлгий, авлига тэнд нүүрлэсэн гэдэг нь ойлгомжтой болсон. Тийм ч учраас ард түмний хяналтад хувийн өмчийн компанийн шийдвэр гаргалтаас арай өөр онцлог ийм бие даасан Төрийн өмчийн компанийн хуультай байх шаардлагыг дэмжиж байгаа.

Өнгөрсөн оны 4 сард Парис хотод төвтэй Олон улсын эдийн засаг, хамтын ажиллагааны байгууллагад манай улс энэ хуулийн төслөө нэг өдөр бие даасан хэлбэрээр дэлхийн олон улсын байгууллагуудад танилцуулсан байдаг юм. Олон улсын эдийн засаг, хамтын ажиллагааны байгууллагаас гаргасан төрийн өмчийн компанийн засаглалын стандартыг энэ хуулийн төсөл би нутагшуулсан гэж ойлгож байгаа. Тэгэхдээ нэг хуультай хамт шийдэх ёстой. Тэр нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуультай хамт шийдэж байж энэ бүтэн болно. Дангаараа бидний зорилго, зорилт хангагдахгүй. Хэлэлцсэний, хэлэлцэх эсэхийг шийдсэний дараа энэ асуудал дээр ажлын хэсэг гарахдаа би ХЗБХ-той хамтарсан Эдийн засгийн байнгын хороо ажлын хэсэг гаргаж яваасай, цуг хэлэлцээсэй гэсэн саналтай байгаа. Мөн, минутаа сунгаад авчих уу? 1 минут.

**Р.Сэддорж:** 1 минут.

**Б.Энхбаяр:** Яагаад гэхээр компанийн харилцаа өөрөө хууль зүйн хувийн эрх зүйн харилцаанд яаж оролцох вэ, шийдвэр гаргалтууд нь ямар байх вэ гэдэгтэй холбоотой хууль зүйн асуудлууд хөндөгдөж байгаа. Тэр ч утгаараа өнгөрсөн парламентын үед энэ хуулийн төслийг Хууль зүйн яам толгойлж, Нямбаатар сайд өргөн барьж байсан хууль юм. Тэгээд шинэ парламент гарсантай холбоотой төсөл буцаагдчихсан. Өнгөрсөн парламентын үед миний бие ажлын хэсгийг нь ахалж байсан Улсын Их Хурал дээр. Сонгууль болоод дөхөх гээд энэ том хэмжээний реформыг батлуулж амжаагүй. Тийм учраас би үргэлжлүүлээд энэ хуулийн төслийн хэлэлцэх асуудлыг шийдсэний дараа даруухан биш сонсогдож байж магадгүй. Тэгэхдээ энэ хуулийн төслийг Улсын Их Хурал дээр ажлын хэсгийг нь ахалж, манлайлж, батлуулах ийм хүсэл эрмэлзэлтэй байгаа гэдгийгээ эрхэм гишүүддээ танилцуулъя.

**Р.Сэддорж:** Үг хэлж байна уу, хариулт байгаа юу? 5 номер Учрал сайд.

**Н.Учрал:** Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг ажлын хэсэг гаргаад ажиллаж байгаа. Тэгэхээр Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийг ирэх хаврын чуулганаар өргөн мэдүүлэхээр зорьж байна. Тэгээд би Энхбаяр гишүүний саналтай санал нэг байгаа. Төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн компанийн асуудлыг ч, өмчийнх нь асуудлыг ч ер нь нэгэн цагт хамтад нь шийдвэрлэж байж цаашдаа томоохон реформ хийхэд том түлхэц болно. Гэхдээ сая яагаад энэ Төрийн өмчийн компанийн бүтээмж, засаглал, ил тод байдлыг сайжруулах хууль гээд тухайлан эхэлж оруулж ирсэн бэ гэвэл мэдээж ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн 14 эрх зүйн реформын тэргүүн эгнээнд байгаа ийм реформ.



2-т хууль хүлээхгүйгээр ЗГ өөрийн бүрэн эрхийнхээ хүрээнд шийдэж болохуйц асуудлуудыг шийдвэрлээд явж байгаа юм. Ийм цаг үетэйгээ нийцүүлсэн. Тэр уул уурхайн компаниуд, уул уурхайн бус компаниуд тэр холдингийн зарчмаар ажиллах, энэ давхардсан чиг үүргийг бууруулах, нэгтгэх, нийлүүлэх, өөрчлөн зохион байгуулах ажлууд шат дараалалтай, үе шаттай хийгдэж байгаа юм. Тийм учраас хуулийг даруй гаргахгүй бол яг үнэнийг хэлэхэд энэ ТУЗ-ийн хараат бус гишүүдийг сонгон шалгаруулахыг, хараат гишүүдийг ч гэсэн томилох, сонгох, нээлттэй зарлах асуудал дээр улс төр нь их том. Тийм учраас хуулиа гаргаж авчхаад, хуулиа бариад ажлаа хийхгүй бол Төрийн өмчийн хороо ч тэр, Эрдэнэс Монгол нэгдэл ч тэр, энэ Хэрэг эрхлэхийн дэргэд ажилладаг. Тэгэхээр үүнд нөгөө яг хуулиа л барьж ажиллахгүй бол улс төрийн нөлөө, улс төрийн хамаарал үргэлж байсаар байх юм билээ.

Тийм учраас эрхэм гишүүд та бүхнээс энэ ТУЗ-ийн гишүүдийн шалгуур шаардлагуудыг өндөр болгоод, босгуудыг нь нэлээн өндөр болгоод, мэдээллийг нь ил болгоод төрийн өмчийн компаниудыг үнэхээр чадвартай менежер удирдахаас өөр ямар ч боломж бололцоогүй болсон хатуу хуульчилсан хууль гаргаад өгчихвөл хуулиа бариад ажлаа явуулахгүй бол ингээд хараат бус олон гишүүд чинь хараат болчих эрсдэлтэй байгаа юм. Ер нь ингээд яваад ирчихсэн учраас энэ хууль ЗГ-ын нэн тулгамдсан асуудал байсан учраас энэ хуулийг оруулж ирсэн. Тэгээд тэр төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн компани, өөрөө Орон нутгийн өмчийн хуулийг ирэх чуулганаар өргөн мэдүүлээд, хамтатгаад хэлэлцээд явахыг дэмжиж байна.

**Р.Сэддорж:** Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн.

**Д.Энхтүвшин:** Өнгөрсөн жилүүдэд яах вэ бид хэд Үндсэн хуулиараа чөлөөт зах зээлийн эдийн засагт энэ чиглэлийг илүү сонгосон ч гэсэн яг бодит байдал дээр эдийн засаг дээр төр давамгайлсан хэвээрээ байгаа. Бид сая төсөв батлахад төсөв маань 35 хувьтай, энэ ТӨК-удын хэмжээ маань яг төсвийн зарлагатай бараг тэнцүү хэмжээний дүн байгаа. Тэгэхээр ингээд 70 хувь. Бусад хувийн хэвшил гээд аваад үзэхээр топ 100 ААН-үүдийн бараг 90 нь төрөөс олгодог зөвшөөрөл лиценз дээр суурилдаг бизнесүүд байгаа. Тэгэхээр өөрөөр хэлбэл манай улсад эдийн засаг маань бүхэлдээ шахуу улс төрөөс хамааралтай ийм байдалтай болчихсон байгаа. Тэгэхээр энийг өөрчлөх зайлшгүй шаардлага байгаа.

Тэгэхээр 1 дүгээрт мэдээж төсвийн хэмжээг буулгах шаардлага байгаа. 2 дугаарт энэ эдийн засаг дахь ТӨК-удын оролцоог багасгах зайлшгүй шаардлага байгаа. Төр бол, хувийн хэвшил бол бүтэлгүйтвэл, амжилтгүй бол дампуураад хариуцлагаа хүлээдэг бол төр буруу хийх тусмаа улам томордог. Энэний жишээ жишээлбэл ТӨК-уд 11 жилийн, 12 жилийн дотор 11 дахин жишээлбэл нийт хөрөнгө нь томорсон тийм жишээ байх жишээтэй. Тэгэхээр зарим компаниуд ашигтай ажилласан гэж ярьж байна. Гэхдээ яг бодит байдал дээр энэ сайн бүтээмжтэйдээ биш угаасаа салбар нь ашгийн түвшин өндөр учраас л ашигтай ажиллаад байгаа болохоос биш бусдаас нь онцлоод жишээлбэл энэ нь ашигтай ажилласан учраас гэдэг байдлаар харьцуулж биш, салбартай нь, өөр компаниудтай харьцуулж байж гарах ёстой. Тэгэхээр бүхэлдээ ТӨК-удын бүтээмжийн хувьд асуудалтай байгаа. Тэгэхээр аль болохоор энэ хэмжээг ТӨК-удыг эдийн засаг энэ төрийн оролцоо, энэ эдийн засагт аж ахуйн харилцаанд орж байгаа энэ хэмжээг багасгаж байж л энэ зөв чиглэл рүүгээ явна. Тэгэхээр хэмжээнд нь байлгах биш, илүү багасгах чиглэлээр л явах ёстой гэж бодож байна.

Тэгээд энэ хуулийг мэдээж сая Сайнзориг гишүүн, Энхбаяр гишүүн эд нар хэлж байна. Яг энэ харилцааг Компанийн тухай хуулиар харьцуулахад зохицуулахад учир дутагдалтай байгаа учраас энэ хуулийг ингээд явуулах нь зөв гэж бодож байна. Тэгэхдээ сая Тамгын газрын дүгнэлт дотор бид нарын анзаарсан нэлээн олон зүйлүүдийг ил гаргаж ирсэн байна лээ. Түрүүн авах, гээхийн ухаанаар гэж хэлж байсан. Тэгэхээр авах юмнууд нэлээн байна лээ шүү гэж хэлмээр байна. Тэгээд би Учрал сайдаас зүгээр асуух юм байна. Энэ өмнө нь Төрийн болон орон нутгийн өмчит тухай хуулиуд, Өмчийн тухай хууль байна, Компанийн тухай хуулиуд байна. Тэгээд нээлттэй гүйцэтгэх удирдлагуудыг нь шалгаруулдаг ийм шалгаруулалтууд явж байсан. Төрийн өмчит үйлдвэрийн газар гээд компанийн зохицуулалт байж байна. Тэрнээс өөр зохицуулалтаар жишээлбэл аж ахуйн харилцаанууд нь яваад байна. Хууль, дүрэм, журам нь байгаа мөртөө одоо ингээд хэрэгжихгүй байдалд байгаад байгаа. Тэгээд энэнээс болоод асуудлууд үүсээд, бид дахиад өөр зохицуулалт хийх гээд байгаа. Та энэ хуулийг гарснаар бид энэ өөрчлөлтийг хийж чадна гэж бодож байгаа юу гэдэг нэг асуулт байна. 2 дугаарт тэр тодорхойлолт дээр би нэг дараа нь нэмэлт дээр асуучихъя.

**Р.Сэддорж:** 5 номер Учрал сайд.

**Н.Учрал:** Би Энхтүвшин гишүүнтэй их санал нэг байгаа. Энхтүвшин гишүүн хувийн хэвшилд ажиллаж байсан, би хувийн хэвшилд ажиллаж байсан. Хэрвээ манай компани ашиггүй ажиллавал хэмнэлт хийнэ, ямар ч ашиг орлого олохгүй бол тэгээд үүд хаалгаа л хаана шүү дээ. Гэтэл ашиггүй байгаад байгаа мөртөө л амьдраад байдаг нь л энэ ТӨК-удын нэг гол их тийм сонин үзэгдэл юм байна лээ. Тэгээд л бүх цалин нь ч хэвээрээ, хангамж нь ч хэвээрээ. Тэгээд компанийг нь албатай юм шиг алдагдалтай ажиллуулдаг, тэгээд яг чи санхүүгийн алдагдлаа огт бууруулсангүй гээд шахаад аудитын нөгөө үндэсний аудит ч, дотоод аудит ч дүгнэлт гаргаад өгчхөөд байхад ажлаа сайжруулъя гэж бодохоос илүүтэйгээр тэгээд зарим хүн рүү залгадаг, намайг авраач гээд. Тэгээд ингээд эхлэхээр чинь ерөөсөө энэ юун тэр Компанийн хуулиар чөлөөтэй хаях. Энэ чинь шал өөр онцлогтой кэйс юм байна лээ энэ төрийн өмчийн компани чинь. Бидний мэдэхгүй кэйс юм байна лээ.

Тэгэхээр нөгөө ашигт ажиллагаанаас илүүтэйгээр хэн намайг аврах вэ гэдэг нь чухал болчихсон. Тэдэнд тэр компанийг ашигтай ажиллуулах нь чухал биш байгаа байхгүй юу. Тэгэхээр хуулиар ерөөсөө энэ босго шаардлагуудыг асар тодорхой болгоё. Тэгээд хуулиа бариад эд нартайгаа ярья. Үнэхээр ТӨК-ийг ашигтай ажиллуулж байгаа сайн менежерүүд байна, тэрийг үгүйсгэхгүй шүү дээ. ТӨК-д ажиллаж байгаа сайн менежерүүд маш их байгаа. Гэхдээ нэг юм байдаг юм байна. Энэ хувийн хэвшилд нэг KPI тавиад л, гүйцэтгэлийг нь үнэлээд л ингээд явдаг, бизнес төлөвлөгөөгөө ороод батлуулаад л явдаг. Тэгэхдээ бизнес төлөвлөгөө бол өмнөхдөө биш, өөр компаниудтай, нөгөө салбарынх нь би тэр бенчмарктай харьцуулах шаардлагатай шүү дээ. Гэтэл нөгөө компаниуд яадаг вэ гэхээр нөгөө бизнес төлөвлөгөөгөө давуулахын тулд нэг өөртөө таарсан нэг ийм төлөвлөгөө хийчихдэг нэг хөнгөхөн хэдэн зорилт биччихдэг. Тэгчхээд тэрийгээ оруулаад бид ингээд төлөвлөгөөгөө батлуулсан гээд.

Жишээ нь хувийн компаниуд танай энэ компани ямар ашигтай ажиллаж болох юм, ямар потенциалын компани юм бэ гэдэг дээр нь нөгөө KPI-г нь тавиад ингэж шахаж ажиллуулдаг байхад байгаагаасаа урагшлах ямар ч зорилгогүй,

өөртөө тохирсон нэг ийм бизнес төлөвлөгөө оруулчхаад, тэрийгээ аргацаагаад өнгөрөөгөөд байгаа. Тэр салбарынх нь тэр бенчмарк энэ тэртэй харьцуулж байгаа юм ерөөсөө байхгүй. Тийм. Тэгэхээр энэ хуулиар бид яг хувийн хэвшилтэй адилхан эд нарыг ингээд нэг КРІ-тай болно, тавьж өгнө. Дээрээс нь гүйцэтгэлийн үнэлгээгээ нэг жил болгон оруулна. ТУЗ-ийн гишүүд өөрсдөө эрх, үүрэгтэй болно. ТУЗ-ийн гишүүд.

Тэгээд ер нь ингээд бие даах бололцоог нь хангуулаад, ер нь энэ хууль гарах юм бол ТӨК-ийн захирал хийх, ТУЗ-ийн гишүүн болох шалгуур ер нь их өндөр болно доо. Тэгэхээр тэгж их нэг их хүн амьтнаар яриулаад ороод байдаг чинь их багасна даа. Чаддаг нь энэ төрийн өмчийн компанийг удирдах байх. Ингээд эхлэхээр цаашдаа ТӨК-ийн удирдлагууд үүнийгээ дагаад хамгийн нэр хүндтэй, улс орондоо гавьяа байгуулж байгаа, баялгийн санд орлого төвлөрүүлж байгаа ийм сайн менежерүүд шүү гэдэг ийм нийгмийн зөв хандлага дэмжлэг бий болохгүй бол ТӨК гэхээр л муу муухайн үүр байж болохгүй л дээ. Энийг чинь нэг бүгд биш, нэг хэсэг бүлэг нөхдүүд л ийм нэр зүүлгэж өглөө шүү дээ. Тэгэхээр цаашдаа хамгийн сайн менежерүүд уригдаж ирж ажилладаг, богино хугацаанд ажил сайжруулдаг ийм байдал руу хэвшүүлэхийн тулд энэ ТӨК-ийн бүтээмж, засаглал, ил тод байдлыг сайжруулах хуулиараа тавьсан шаардлагуудаа ерөөсөө энэ ажлын хэсгүүдийн Их Хурлын гишүүдийн ажлын хэсгээс хүсэхэд ерөөсөө буулгаж болохгүй шүү. Яагаад гэхээр зарим салбарынхан, бүр зарим үе үеийн сайд нар, гишүүд ингээд лоббиддог байхгүй юу. Тэгээд зовооно. Тэгэхээр энэ дээрээ хатуу байгаад л аваад л гарчихвал ажил хийхэд их.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Энхтүвшин гишүүн 1 минут.

**Д.Энхтүвшин:** Хуулийн төсөлтэй холбоотой энэ саналууд бол нэлээн байгаа. Тэгээд энэ дээр нэг бүрчлэн яриад яах вэ. Ер нь хуулийг хэлэлцэхийг дэмжиж байгаа. Тэгээд энийг улам сайжруулж, ТӨК-удыг илүү цэгцэд нь оруулах шаардлага энэ дээр ажиллах ёстой гэж бодож байна. Тэгээд миний хувьд ч гэсэн Улсын Их Хурал дээр яг энэ ажлын хэсэг Байнгын хорооноос ч юм уу ажлын хэсэг гарвал ажлын хэсэгт нь орж ажиллах хүсэлтэй байна. Тэгээд амжилт хүсье.

**Р.Сэддорж:** Баярлалаа. Мэндбаярын Мандхай гишүүн.

**М.Мандхай:** Миний хувьд хувийн хэшилд ажиллаж байсан, удирдах түвшинд ажиллаж байсан хүний хувьд ер нь энэ хуулийг оруулж ирэх нь зүйтэй гэж бодож байгаа. Тэгээд Учрал сайдын энэ гаргаж байгаа санаачилгыг дэмжиж байгаа. Яагаад гэхээр ингээд харахаар өр төлбөр болон хөрөнгийн харьцааны үзүүлэлтээс харвал бараг 40 хувь нь эрсдэлтэй гэсэн дүгнэлт гарсан байна лээ. Тэгээд нийт 43 компани алдагдалтай ажиллаж 150 тэрбум төгрөгийн алдагдалтай байна гэдэг энэ бол үндсэндээ яг шаардлагагүй компаниудыг эндээс харж байгаад татан буулгахыг нь татан буулгамаар байгаа юм. Яг зоригтой татан буулгаад, яг үнэхээр стратегийн хувьд ач холбогдолтой үнэхээр авч явах ёстой гэсэн төрийн болон төрийн өмчит энэ компаниудыг яг энэ бүтээмжийг нь сайжруулаад, үлдээгээд сайжруулж ажиллах нь зүйтэй гэж бодож байгаа.

Тэгээд гол нь энэ нэрэн дээрээ ингээд бүтээмж гэсэн мөртөө яг хуулиа харахаар яг дорвитой бүтээмж талаасаа заалтууд хангалттай биш харагдаж байна. Тийм болохоор ялангуяа энэ КРІ үзүүлэлтийг нэлээн тодорхой болгож оруулж өгмөөр байгаад байгаа юм. Жишээлбэл яаж энэ зардлыг өсөхгүй байлгах

дээр ямар KPI үзүүлэлтүүд байх, үр ашигтай ажиллах тэр санхүүгийн үзүүлэлтүүдийг жишээлбэл маш тодорхой оруулж өгөөч гэсэн саналтай байна. Хуулийн 14 дүгээр зүйлд хөрөнгө олж авах тухай гарчигтай мөртөө та хэд сайн хараарай. Эсвэл би буруу ойлгоод байгаа юм болов уу. 14.3-аас хойш дандаа энэ худалдах тухай заалтууд нь орж байгаа нь өөрөө энэ гарчигтайгаа ерөөсөө зохицохгүй байгаад байгаа заалтууд 14.3-аас хойшоогоо заалтуудыг нь сайн хараарай.

30 дугаар зүйл дэх энэ цалин, урамшуулалтай холбоотой тухайн компани алдагдалтай ажилласан тохиолдолд цалин, урамшууллыг багасгах тухай заалт боломжтой бол бүр нэмж оруулмаар байгаад байгаа юм. Яагаад гэхээр энэ ТУЗ-ийн гишүүн нь хуулийн 29.6-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэх байгаа тул энэ дээр энэ заалтыг тусгаач гэсэн саналтай байна. Мөн 35 дугаар зүйл дээр гүйцэтгэх захирлын цалин, урамшуулал хэрэв компанийн энэ хөрөнгийн ашигт ажиллагаа, өгөөж, зах зээлд эзлэх байр суурь буурсан тохиолдолд яах юм бэ? Тэгвэл энэ урамшуулал олгохгүй байвал урамшууллыг ер нь авдаггүй байвал эсвэл буулгах ийм заалтыг нэмж оруулж өгөөч гэсэн саналтай байна.

Бас нэг энэ заалт дээр төрийн өмчийн компани нэг асуудалтай юм нь авлигал, ашиг сонирхол гэдэг асуудал байнга хөндөгддөг. Тэгэхээр энэ авлигын эсрэг, ашиг сонирхлоос ангид байх ямар зохицуулалтуудыг тодорхой оруулж өгөх юм бэ? Энэ нь энэ дээр уншигдахгүй байгаад байна. Хэрэв шүгэл үлээгч компаниас гарч ирээд энэ авлигатай холбоотой болон, 1 минутаа авчихдаг. Ашиг сонирхлоос.../минут дуусав/

**Р.Сэддорж:** 1 минут Мандхай гишүүн.

**М.Мандхай:** Энэ шүгэл үлээгч хэрвээ гарч ирээд энэ ашиг сонирхол болон авлигатай холбоотой асуудлыг ил болгож гарахад тэр шүгэл үлээгчийг хамгаалах ямар механизмуудыг оруулж өгөх юм бэ? Энийг бүр хууль дээр тодорхой оруулж өгмөөр байна. Бид ингээд орчин үетэйгээ хөл залгуулж явж байгаа. 43, 47.3 буюу компанийн тайланд тусгах үзүүлэлтээр энэ ESG энэ ... асуудлыг оруулж, тодорхой оруулж өгмөөр байна. Байгаль орчин, нийгэм, засаглалын чиглэлээр хийсэн ажлыг оруулаад. Тэгээд ингээд бид чинь цаашид тогтвортой хөгжлийг бий болгохоор зорьж байгаа учраас төрийн байгууллагууд ч гэсэн энд хувь нэмэр оруулж ажилладаг баймаар байна. Энэ заалтууд дээр анхаарч ажиллаарай. Тэгээд асуултдаа хариулт авчихъя.

**Р.Сэддорж:** Хариулт 5 номер, Учрал сайд.

**Н.Учрал:** Ер нь энэ хуулийг шууд төрийн болон орон нутгийн өмчийн компанийн хууль гэж нэрлэснээс илүүтэйгээр энэ бол үүргээ биелүүлэх нэг удаагийн хууль ч байж магадгүй. Үүргээ биелүүлсэн тохиолдолд хуультай, хуульгүй ТӨК-уд ашигтай, зөв засаглалтай ажиллах цаг ирнэ. Тэгэхээр энэ бол яг өнөөдрийн нөхцөл байдалд нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн хууль учраас бүтээмж, засаглал, ил тод байдлыг сайжруулах хууль гэж хуулийн нэршлийг оноосон. Тэгээд төрийн бүтээмж гэдэг угаасаа байгаа нөөцөө хэрхэн зөв хуваарилах вэ, ашигт ажиллагаагаа хэрхэн нэмэгдүүлэх вэ гэдэг рүү л чиглэж байгаа. Тэгээд бүтээмж дотроо мэдээж тэр компанийн зорилго, стратеги, тэр алсын хараа, мөн ил тод байдал, хариуцлага, ёс зүй, хяналт гээд л нэг ийм 6 чиглэл рүү л зорьж байгаа шүү дээ. Ингэснээрээ л бүтээмж сайжирна. Энэ ч

утгаараа бид нарыг эргээд харахаар байгаа нөөц маань байгаа мөртөө бид зөв хуваарилж чадахгүй байна.

Тийм учраас яг тэр нөгөө алсын хараанд нь тохирсон KPI дээр мөрдөх тэр гол шалгууруудыг нь тавих ёстой болохоос биш яг ямар, ямар индикаторуудаар хэмжих юм бэ гэдгийг хуульчилна гэж байхгүй. Тийм учраас тэр KPI-г компани болгон өөр өөрөөр, тэгээд өөр өөрийн онцлогоосоо тавиад, гэрээндээ тусгаад, үүнийгээ үнэлүүлээд явдаг энэ л зөв жишгийн дагуу явах ёстой. Тийм учраас KPI дээр зүгээр ийм үндсэн шалгууруудыг нь хуульд нь ерөнхий байдлаар тусгаад явж байгаа юм. Тэрнээс биш бүгд нарийвчлан KPI хуульд оруулах бололцоогүй. Гэхдээ ямар ч байсан энэ компаниуд тэр бизнес төлөвлөгөөгөө батлуулдаг, KPI-аа үнэлүүлдэг, үнэлгээнийхээ дагуу урамшуулал авдаг, тэр нь ил тод байдаг, тэр нь өөрөө хүлээн зөвшөөрөгдөхүйц байдаг. Нэг ёсондоо компанийг баялгийн санд орлогыг 2 дахин нэмэгдүүлчихсэн компанийн захирал өндөр цалин, урамшуулал авах нь зүй ёсны хэрэг шүү дээ. Энэ KPI-г нь үнэлээд л шийддэг. Тэгэхээр энэ механизм өөрөө ил тод ингээд болоод эхлэхээр үүнд их тийм шударга байдал, нөгөө шударга байдал бий болно л доо. Энэ утгаараа ийм ерөнхий байдлаар хуульчилсан.

Тэр ESG-тэй холбоотой заалт хуулийн 39.4 дээр туссан байгаа шүү. Тийм, бизнес төлөвлөгөөнд энэ асуудал ESG-г нөгөө байгаль орчин, нийгэм, тэр нөгөө соёлын асуудал буюу нөгөө хүлэмжийн хийг бууруулах, нийгмийн хариуцлагын чиглэлээр үйл ажиллагаа явуулах асуудлыг заавал бизнес төлөвлөгөөнд тусгана гэж оруулсан нь энэ хуулийн орчин цагтай нийцүүлсэн их том дэвшил. Тэгээд Мандхай гишүүн өмнө нь ч гэсэн энэ саналуудыг хэлж байсан. Ер нь энэ ESG-г барих шаардлага маш их зөв, энэ компаниудын зөв хөгжлийн тренд болчихсон. Тийм учраас ТӨК-уд ч гэсэн эндээс холдох бололцоо байхгүй. Тэгэхээр энийг ингэж оруулж өгсөн гэдгийг хэлье.

**Р.Сэддорж:** 6 номер нэмэлт хариулт.

**Д.Цолмон:** Мандхай гишүүний асуултад хариулъя. ЗГХЭГ Цолмон. 14 дүгээр зүйлд яг энэ хувьцаа олж авах асуудал байгаа. Тэгэхээр ерөнхийдөө хуулийн төсөл дээр ТӨК-ийн 5 үндэслэлээр компанийг шинээр үүсгэн байгуулах асуудал тусгагдсан. 14 дээр ерөнхийдөө байгаа хувьцааг ямар тохиолдолд олж авч болох вэ гэдэг энэ зохицуулалт орж ирж байгаа 14.2 дээр та харж байгаа бол энэ бэлэглэл, өв залгамжлалын замаар, шүүх, арбитрын шийдвэрийн дагуу, харин тийм одоохон. Энэ ингээд үндэслэлээр хэрвээ 34-өөс дээш юм уу 34-өөс доош хэмжээний хувьцаа төр юм уу, орон нутаг эзэмших тохиолдолд энэ хувьцаагаа хэрвээ 34-өөс доошоо юм бол та худалд гэж байгаа юм. Хэрвээ энэ нь өөрөө нээлттэй компани байх юм бол тэр нээлттэй компанийнхаа нөгөө биржээрээ Хөрөнгийн биржээрээ худалдаалах замаар явна. Хаалттай компани байх юм бол та тухайн хувьцааны үнэлгээг хийгээд, энэ хувьцааг зарахтай холбоотой зардлыг нэмээд ингээд бусад нөгөө Компанийн тухай хуульд заасан бусад хувьцаа эзэмшигчдэд санал болгох замаар ингээд хувьцаагаа худалдаад яв.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн.

**М.Бадамсүрэн:** Би энэ хуулийг дахин боловсруулж, өргөн мэдүүлэх ёстой гэж байр суурьтай байна. Хэрвээ Улсын Их Хурлын гишүүдийн олонх нь дэмжээд

явахаар бол энэ ажлын хэсэгт нь орж ажиллах саналтай. Яагаад гэдгээ би тайлбарлая. Энэ хууль амьдралд илүү ойрхон байх ёстой. Өөрөөр хэлбэл нийслэлийн захын дүүрэг, орон нутагт. Энд төр зөвхөн стратегийн салбарт л цаашдаа ТӨК байгуулах ёстой. Өөрөөр хэлбэл бид чөлөөт хувийн хэвшлийг зах зээлийг дэмжсэн эдийн засгийг баримталж ажиллаж байгаа орон учраас энэ үйлчилгээний салбарыг бүхэлд нь хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх ёстой. Өмнө нь Сангийн яамнаас энэ хуулийг энэ чиглэлийн шинэчлэлийг хийсэн шүү дээ.

Тэгээд харамсалтай нь ямар зүйлээс болоод энэ нь зогсчихсон гэхээр одоо байгаа энэ орон нутгийн өмчит, төрийн өмчит энэ үйлчилгээний салбарт ажиллаж байгаа компани тухайлбал хот тохижилтын компанийн ажилтнууд би тэтгэвэртээ гарахад тэтгэмж авч чадахгүй ийм нөхцөлд орлоо гэдэг үндсэн шалтгаанаар энэ бол зогссон шүү дээ. Тэгэхээр энийг яаж шийдэх вэ гэхээр одоо ажиллаж байгаа ажилтан тэтгэвэртээ гарахад яг төрд ажиллаж байгаатай адилхан энэ тэтгэмжийг нь өгдөг, банк санхүүгийн байгууллагаас зээл авахад нь боломж олгодог энэ тогтолцоог одоо ажиллаж байгаа хүн тэтгэвэртээ гарч дуусах хүртэл хугацаанд нэг удаа зохицуулаад явах юм бол энэ хувийн хэвшил чинь жижиг энэ үйлчилгээний салбарыг бүрэн аваад явах боломжтой.

Тэгэхгүй бол ингээд нийтийн үйлчилгээний төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх дээр бид компани байгуулахыг зөвшөөрнө гээд л заачихсан. Яг үнэндээ төрийн өмчит улсын төсөвт аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, улсын төсөвт үйлдвэрийн газар гэдэг нэрийг л компани болгосон ийм механик өөрчлөлт хийсэн болохоос биш яг энэ хувийн хэвшил рүү төрийн үйлчилгээг шилжүүлэх асуудал ерөөсөө энэ дээр маш тийм хязгааргүй байдлаар орчихсон байгаа байхгүй юу. Тэгэхээр төр зөвхөн стратегийн салбар буюу уул уурхай, эрчим хүч, төмөр зам, дэд бүтцийн ус, бохир татах, татан зайлуулах энэ салбартаа үйл ажиллагаа явуулбал явуулаад бусад бүх юмыг хувийн хэвшилд шилжүүлэхгүй бол болохгүй. Тэгвэл энэ төр чинь данхайгаад л байна, энэ төрийн өмчийн, орон нутгийн өмчийн байгууллагын дарга нар чинь нэмэгдээд л байна.

Хувийн хэвшилд боломж олдохгүй. Энэ чинь хувийн хэвшил өрсөлдөж чадахгүй байхгүй юу. Бид жирийн иргэдийг яаж ажлын байртай болгож, тэдний бизнес эрхлэх сэтгэхүй ийм арга барилтай болгож өсөн дэвжих боломжийг олгох вэ гэдгийг л энэ хууль дээр оруулж өгөх ёстой. Жишээлбэл орон нутагт жишээлбэл ингэж байна шүү дээ өрхийн эмнэлэг байна. Би яг амьдрал дээр жишээ дээр ярьж өгье. Өрхийн эмнэлгийг яадаг вэ гэхээр барилгыг нь барьж өгөөд, өрхийн эмнэлэг зөвхөн нэг хүнд ноогдох хувьсах зардлаараа л үйл ажиллагаа явуулдаг байхгүй юу. Энэ бол төр, хувийн хэвшлийн түншлэлийн нэг хамгийн ил байгаа ийм жишээ. 2-т нь гэхэд жишээлбэл Дорнод аймагт эмийн сан байгуулахгүй байгаа тохиолдолд.../минут дуусав/

**Р.Сэддорж:** 1 минут, Бадамсүрэн гишүүн 1 минут.

**М.Бадамсүрэн:** Иргэд захын дүүргүүдэд эмийн сан байгуулахгүй болохоор бид төсвөөсөө зөвхөн түрээсийг нь төлөөд хариуцаад ингээд хувийн хэвшил эмийн сангийн үйл ажиллагаа явуулж байна. Жишээлбэл халдвартын эмнэлэг. Хувийн хэвшлийн халдвартын эмнэлэг хүмүүс байгуулахгүй байгаа учраас бид зөвхөн түрээсийг нь төлөөд, энэ эмнэлгээ байгуулаад амжилттай хэрэгжиж байгаа туршлага Дорнод аймагт жишээлбэл байна. Жишээлбэл мал эмнэлгийн үйлчилгээ байна. Энийг яадаг вэ гэхээр мал эмнэлгийн үйлчилгээ дээр төрөөс барилга

байгууламжид хөрөнгө оруулалт хийж болно, өөрөөр хэлбэл хувийн хэвшил чадахгүй байгаа зүйл дээр нь дэмжээд, харин малынх нь үйлчилгээний төлбөрийг нь тооцоод энэ хувийн хэвшлээр гүйцэтгүүлдэг гэх мэтчилнээр ингэж ийм өөрөөр хэлбэл миний хэлэх гэж байгаа дүгнэлт нь үйлчилгээний салбарыг бүхэлд нь хувийн хэвшилд шилжүүлээч. Энд ноогдох тэр тариф, зардал, тооцоог нь төсөв дээрээ тооцоод, Төсвийн тухай хуульдаа өөрчлөлт оруулаад юм уу, шинэчлэл хийгээд явахгүй бол энэ бол яг үнэндээ үйлчилгээний салбарт замбараагүй ТӨК байгуулах боломжийг бүрдүүлдэг ийм төсөл байгаа.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Хариулт 5 номер. Батнайрамдал гишүүнийг асуулт дээр нэмнэ.

**Н.Учрал:** Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя. Дотоодын нийт бүтээгдэхүүнийг өмчийн хэлбэрээр нь харьцуулж үзвэл энэ хувийн хэвшил 71,6 хувь, төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой компани ААН-үүд 24,7 хувийг эзэлдэг. Үүнээс салбар бүрээр нь аваад үзвэл жишээ нь тээвэр, боловсролын салбар 80 хувь, усан хангамжийн салбар 80 хувь, уул уурхай 39 хувийг л бүрдүүлж байгаа юм байна лээ ТӨК-уд дээр. Эндээс юу харагдаад байна вэ гэхээр ерөөсөө бид төр одоо заавал авч явах шаардлагатай тэр стратегийн салбаруудыгаа авч явж байгаад, цаашдаа хувийн хэвшилд шилжүүлэх тэр бэлтгэл ажлыг хангах ийм огт оролдлого хийхгүй байгаагаас болоод бэлэн биш, нэг ёсондоо боломж бид олгохгүй байгаа. Тийм учраас би Бадамсүрэн гишүүнтэй санал нэг. Ерөөсөө л энэ хувийн хэвшилд шилжүүлэх.../минут дуусав/

**Р.Сэддорж:** 5 номер гүйцээж хариулъя.

**Н.Учрал:** Хувийн хэвшил шилжүүлэх ёстой, аутсорсинг хийх ёстой, нэгтгэх ёстой, өөрчлөн зохион байгуулах ёстой, хөрөнгө мөнгө босгох чиглэлээр нээлттэй компани болгох хэрэгтэй. Энэ шийдвэрийг зөвхөн Их Хурал гаргадаг Их Хурал. Тийм учраас энэ хууль батлагдсаны дараа ТӨК-уд дээр баримтлах үндсэн чиглэлийг ЗГ оруулж ирэхдээ дагуулаад тогтоолоор аль, аль компанийг нээлттэй болгох юм, аль, аль компанийг нэгтгэх юм, өөрчлөх юм, зохион байгуулах юм бэ гэдгээ хамтад нь шийднэ. Энэ хууль гарснаараа зах зээлийн судалгаануудыг заавал хийгээд, төвлөрөл багатай төр заавал оролцох хувийн хэвшил өрсөлдөх боломжгүй, даах боломжгүй салбарууд дээрээ л төр компани байгуулахаар зах зээлийн судалгаанд үндэслэсэн тэр үндэслэлээ ЗГ-т эсвэл өөрөө удирдах байгууллагадаа оруулна. Тэр салбар нь тавхан салбар байна. Таны хэлж байгаа нийтийн зориулалттай дэд бүтэц, нийтийн үйлчилгээний салбар, энэ эмнэлэг, сургууль, ашигт тэр нөгөө АЗЗА, хог юу байдаг юм ийм нийтийн үйлчилгээний зориулалттай байгууллагууд нь.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Бадамсүрэн гишүүн тодруулж асууя.

**М.Бадамсүрэн:** Үгүй ээ, үгүй. Энэ хуулийн төслөөр чинь болохоор үйлчилгээний салбарт ингээд хязгааргүй байгуулахаар болчихоод байгаа байхгүй юу энэ хуулийн төсөлд чинь. Би уншаад хэлээд байна шүү дээ. Тийм учраас энийг хүрээг нь хумьж өгөхгүй бол болохгүй. Одоо хувийн хэвшил гүйцэтгээд байгаа юман дээр дахиад орон нутгийн өмчит ТӨК байгуулах боломж чинь энэ дээр нээлттэй болчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг энэ хуулиар одоо энэ шинэчлэлээ хийж өгч чадахгүй юм бол энэ чинь цаашаа шинэчлэл хийгдэхгүй байхгүй юу. Тэгэхээр хувийн хэвшлийнхэн өрсөлдөх боломжийг орон нутгийн өмчит ТӨК-уд, ЗГ, орон нутгийн иргэдийн Хурал энэ дээр орон нутгийн өмчит

компани, ТӨК байгуулсаар болох болно. 1 дүгээрт энийг тодорхой. 2 дугаарт нь орон нутгийн эрхийг яагаад хязгаарлаад байгаа юм бэ? Орон нутагт зөвхөн нийтийн үйлчилгээ дээр компани байгуулна. Өмнө бусад салбарт компани байгуулах боломжтой байсан эрхийг нь ямар үндэслэлээр хассан бэ? Өөрөөр хэлбэл Засгийн газар, Улсын Их Хурал төр лүү бүх эрх мэдлийг аваад яг Төрийн хэмнэлтийн хууль шиг орон нутгийн эрхийг хязгаарлаад байна. Энэ дээр.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Хариулт 5 номер.

**Н.Учрал:** Бадамсүрэн гишүүнээ энэ хууль гарснаар компани байгуулах ер нь боломжгүй болно шүү төр бүх салбарт. Яагаад гэхээр 8.1.1 дээр нийтийн зориулалттай дэд бүтэц, нийтийн үйлчилгээний салбар гэж байгаа энэ бол. Гэхдээ үндсэн шаардлага дээр нь зах зээлийн төвлөрөл багатай, хувийн хэвшил дангаараа гүйцэтгэх боломжгүй салбар гэдгийг үндсэн шаардлага болгосон. Тийм учраас зах зээлийн судалгаа, үндэслэлээ орж ирэхдээ зах зээлийн төвлөрөл багатай, хувийн хэвшил дангаараа гүйцэтгэх боломжгүй гэдэг нь 1 дүгээр шаардлага байхгүй юу. Энд нийцэхгүй бол байгуулах бололцоо байхгүй.

Таны хэлж байгаа орон нутгийн асуудал дээр Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хууль дээр орон нутаг чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор л орон нутгийн өмчит компани байгуулна гэж заасан. Энэ хуулийн зохицуулалттай манай энэ хуулийн заалт нийцэж байгаа юм. Угаасаа л ийм.

**Р.Сэддорж:** Батнайрамдал гишүүнийг асуултаас хасъя. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Чуулганы, намрын чуулганы хаалтын өдрүүд явагдаж байгаа учраас Байнгын хорооны гишүүд чуулганы нэгдсэн хуралдаандаа санал хураалтад оролцоод, эргэж ирж үг хэлэх гишүүдийн нэрсийг авна. Зарим нь байхгүй байгаа учраас ирээд л авъя. Тэгвэл гишүүд яг энэ хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж үг хэлэх гишүүд нэрсээ өгчихье? Тэгээд нэмэх боломж олгоё гишүүддээ. Сайнзориг, Батболд гишүүнээр үг тасаллаа.

*Хуралдаан 11 цаг 39 минутаас 12 цаг 05 минутад түр завсарлав.*

Саяын 4 гишүүн энийг нэмээрэй. Бадамсүрэн, Батболд гишүүн байсан, Энхцэцэг гишүүн байсан, Сайнзориг гишүүн байсан, Бадамсүрэн гишүүн байсан. Байнгын хорооны хуралдаан үргэлжилнэ. Ирц, үг хэлэх гишүүд нэмэгдэх боломжийг олгоно. Үг хэлж эхэлье. Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан байр сууриа илэрхийлж гишүүд үг хэлнэ. Ренчиндоржийн Батболд гишүүн үг хэлнэ.

**Р.Батболд:** Өчигдөр бид нөгөө Байнгын хорооны даргын өрөөнд уулзалтаар ярьсан зүйлүүдээ сайн анхаараарай гэж хэлэх гээд байна. Тэр нийтийн зориулалттай дэд бүтэц, нөгөө компани байгуулах үндэслэл гээд байгаа шүү дээ. Тэгэхээр хувийн хэвшил дангаараа гүйцэтгэх боломжгүй гэдгийг яаж яг тодорхойлох юм. Тэр нөгөө тодорхойлолтуудаа сайн гаргахгүй болохоор нэг ойлгомжгүй нөхцөл байдал үүсчих вий гэдэг асуудал гараад байгаа юм.

Тэгээд тэр үндэслэлийн 3 дээр нь өчигдөр ярьснаараа тэр тодорхой салбарт зүй ёсны монопол үйл ажиллагаа эрхлэх гэдгийг нэг арай өөрөөр тайлбарлаж хэлсэн нь дээр байх. Төрийн монопол үйл ажиллагаа гэхээр наадах чинь нэг л арай



нэг авцалдахгүй юм ойлгогдоод байгаа юм. Энэ хоёрыг нэг анхаараад ажиллаарай. Тэгээд нөгөө орон нутгийн уул уурхайн салбаруудаа дахиад нэмж байгуулагдахааргүй болгоод хорьчих вий энэ хуулиараа тийм ээ. Заавал төрийн өмчтэй байх ёстой гээд заагаад өгчих юм уу. Тэгвэл цааш цаашдаа уул уурхайн компаниуд маань хэцүү л болох байх. Орон нутагтайгаа аятайхан тохироод ажиллах гэхээр заавал ч үгүй төрийн өмчит байх ёстой гээд нааш нь хамаг орлогыг нь татчих гээд байвал хэцүү болчих болов уу гэж бодогдоод байгаа юм. Энийг анхаараад ажиллаарай л гэж хэлье. Баярлалаа.

**Р.Сэддорж:** Мөнхчулууны Энхцэцэг гишүүн.

**М.Энхцэцэг:** Би түрүүний асуусан асуулттай холбоотой саналууд хэлье л гэж бодож байна л даа. Яах вэ ер нь энэ хуулиар Эрчист Монгол гэж компани байгуулаад бүх эрчим хүчний ТӨК-удыг нэгдсэн удирдлагаар хангах ийм компани байгуулах энэ асуудал бид 2001 онд Эрчим хүчний хуулийг анх батлаад эрчим хүчний реформыг хийсэн. Энэ реформын хүрээнд босоо тогтолцоотой байсан буюу Эрчим хүчний удирдах газар гээд нэг ийм байгууллагад удирдагддаг байсан төрийн өмчит компаниудыг бүгдийг нь бие даасан компани болгож хэвтээ буюу хэвтээ тогтолцоотой болгосон. Өөрөөр хэлбэл бие даасан байдлаар үйл ажиллагаа явуулж, бие даасан байдлаар хариуцлагаа үүрээд, яваандаа цаашдаа ийм өрсөлдөөнийг бий болгох гэсэн ийм зорилготой реформыг хийсэн.

Тэгэхээр энэ хуулийн хүрээнд хэрвээ ингээд нэг ийм Эрчист Монгол гээд компани байгуулагдаад, нөгөө эрчим хүчний бүх компаниуд тэр компанид ингээд удирдагдах юм бол яг нөгөө том хэмжээнд хийсэн 2001 онд хийсэн эрчим хүчний реформ буцаад төвлөрсөн тогтолцоо руугаа эргэж орж байгаа юм байна. Энэ бол хөгжлийн маш том дэвшлээс ухарч байгаа асуудал бий болно. Тэгэхээр та бүхэн минь энэ дээр ялангуяа эрчим хүчний салбар мэргэжлийн хүний хувьд энэ дээр онцгой анхаарч үзэх нь зүйтэй юм гэсэн ийм саналтай байна.

Дараагийн нэг асуудал болохоор өнөөдөр Эрдэнэс Монгол гэдэг компанийг уул уурхайн компаниудыг нэгдсэн удирдлагаар хангах байдлаар мэдээж байгуулсан. Тэгээд анхандаа мэдээж хэдэн жил ч тэр үйл ажиллагаа нь тодорхойгүй явсан. Сая ингээд хариултаас харагдаж байх шиг байна. Тэгээд Баялгийн сан одоогийн хууль бий болсноороо баялгийн санг төвлөрүүлэх зорилгоор энэ компани нь нэлээн үйл ажиллагаа нь тодорхой болсон гээд ингээд ярьж байна. Тэгэхээр та нэг юмыг хүлээн зөвшөөрчхөөд байна шүү дээ. Энэ олон компаниудыг удирдах гээд Эрдэнэс Монголыг анх, мэдээж энэ компаниудын үйл ажиллагааг та бүхний яриад байгаа тэр бүтээмжийг, засаглалыг, тэр үйл ажиллагааг нь сайжруулах гээд байгуулсан. Гэвч хэдэн жил ингээд үйл ажиллагаа нь тодорхойгүй ингээд нэг ийм төрийг данхайлгасан компани байж байгаад сүүлдээ Баялгийн хууль бий болсноороо нэг жоохон үйл ажиллагаа нь тодорхой болсон гээд ингээд хүлээн зөвшөөрч байна шүү дээ. Тэгэхээр Эрдэнэс Монгол чинь л яг түүнтэй адилхан ийм үйл ажиллагаа болчих юм биш үү?

Тэгээд зөвхөн баялгийн сангийн төлөө бүхэл бүтэн ийм компани байгуулсан. Дээрээс нь энэ Эрдэнэс Монголынхоо яг үйл ажиллагаа дээр нэлээн дүгнэлт хийж байж эхний жилүүдэд Баялгийн сангийн хууль батлагдахаас өмнө үнэхээр сонин байсан гэж өөрөө ингээд confirm хийгээд баталж байна. Эрдэс Монгол яг л түүнтэй адилхан үйл ажиллагаа болох юм биш үү? Ялангуяа эрчим хүчний компаниудыг ингээд юу яах юм бол. Эрчим хүчний компаниудын хувьд Эрчим хүчний яам гээд

маш том дарга бүтэц байдаг. Түүнтэй адилхан дахиад нэг ийм дарга бүтэц ингээд гараад ирэхээр яаж ч бодсон ийм бүтээмжийг дээшлүүлэх, засаглалыг сайжруулах гэдэг зорилгод чинь мэдээж хүрэхгүй байх л гэж бодож байна.

2 дугаарт мэдээж энэ ТӨК-удын бүтээмжийг, засаглалыг сайжруулах олон арга байгаад байгаа. Хамгийн гол нь л бид төрийн оролцоог багасгах, явал хувийн оролцоо бий болгох вэ, тэр ТӨК-удынхаа ядаж 49 хувь нь ч юм уу төрийн оролцоо, юу хувийн оролцоо бий болж байж л энэ засаглал нь орчин үеийн түвшин рүү, нөгөө бизнесийн үйл ажиллагаа нь ил тод болно, бизнесийн хувьд хариуцлагатай болно гээд ингээд яриад байдаг. Гэтэл олон аргуудаас чухам энэ аргыг сонгож байгаа нь жоохон тиймэрхүү байна л даа. Тэгэхээр энэ бүгд дээр эргэж хараасай гэсэн ийм саналтай байна.

**Р.Сэддорж:** Баярлалаа. Пүрэвжавын Сайнзориг гишүүн үг хэлнэ.

**П.Сайнзориг:** Хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж байгаа. Тэгээд өнөөдөр гишүүд маш чухал саналууд хэлж байна. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн асуудал гэдэг өөрөө эргээд энэ тогтолцооны гажиг хавдар болчихсон Монгол Улсын хувьд болсон байж байгаа. Энэ нь өөрөө улс төртэй ч гэсэн буруу жишиг авчирдаг. Эргээд энэ Монгол Улсын авлигын индексийг ганц хойш татаж байгаа 3 салбарын нэг нь энэ төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалын гажуудал, ил тод бус, улс төрөөсөө хамааралтай, улс төрийн намын далд санхүүжилт болох эрсдэлтэй учраас өнөөдөр олон улсын байгууллагууд ийм дүгнэлтүүдээ өгсөн. Энийг засахгүйгээр бид Монгол Улсын олон зүйлийг засахад хэцүү болно. Энэ реформыг хийе гээд Монгол Улсын ЗГ-аас Оюун-Эрдэнийн ЗГ-аас оруулж ирж байгааг бүрэн дэмжиж байна.

Тэгээд ер нь зүгээр яах вэ хуулийн төсөл дээр сайжруулах зүйлүүд байна лээ. Түрүүн Бадамсүрэн гишүүний хэлж байгаатай би 100 хувь санал нэг байна. Ялангуяа энэ үйлчилгээний салбарууд дээр үнэ тарифын бодлогыг, үнэ тарифыг нь ингээд хатуу тогтоож өгчхөөд түүн дээр хувийн хэвшил орж ирэх сонирхлыг татахгүй байдлаар ингээд олон жил орон нутгийн түвшинд явж ирснийг халах ёстой. Энэ үнэ тарифыг нь зах зээл рүү нь ойртуулаад, хувийн хэвшил энэ зүйлүүдийг хийдэг болмоор байна. Түрүүн тэр Бадамсүрэн гишүүний хэлж байгаа санал дээр ингээд өрхийн эмнэлгүүд хийгээд эхэлчихсэн байхгүй юу. Төр дэд бүтцээр нь хангаад, түүн дээр нь мэргэжлийн хүмүүс хийдэг.

Би бас Энхцэцэг гишүүний хэлж байгаатай санал нэг байна. Хэт их энэ төвлөрөл чинь сүүлдээ энэ том удаашрал, том процесс болоод дунд нь ажил хийдэх вий дээ, дунд нь хариуцлага хийдэх вий дээ. Сүүлдээ үр ашиггүй зардлууд гарах вий дээ. Ийм л зүйл байна. Сая газрын тосны барих үйлдвэрээс ерөөсөө тэгж байна шүү дээ. 1 захирал хэчнээн хүнийг давж гарч ирж Улсын Их Хурал дээр юмаа оруулж ирдэг, сүүлдээ эзвэнгийн үлгэр, би, чи. Би бол зөвхөн эрчимжүүлэх хэсгийг нь хариуцаж байгаа ч гэх шиг. Ийм байдлаар явж байна. Тэгэхээр энэ ТӨК-ийн засаглал дээрээ анхаарах асуудал шүү гэдэг зүйлийг хэлмээр байна.

Тэгээд яах вэ зүгээр ажилчдад нь захиран зарцуулах эрхгүй хувьцаа олгодог асуудал дэлхийн практик дээр байгаа. Энэ дээр нарийн мэргэжлийн салбар болох IT, эрчим хүч ч гэдэг юм уу боловсон хүчнээ тогтоож үлдэх, нарийн мэргэжлийн know how, патент эзэмшдэг энэ компаниуд дээр энэ хувилбарыг бодооч гэдэг зүйлийг би ЗГ-ын ажлын хэсэгт хэлж байгаа юм. Энэ төрийн болон орон нутгийн

өмчит компанийн засаглалын асуудлыг шийдэхгүйгээр энд байгаа бүх хүмүүс нэг хулгайч нэртэй яваад байдаг. Энийг засах цаг нь болсон. Уг нь энд сайн менежерүүд байгаа. Тэгэхдээ түрүүн Энхтүвшин гишүүний ярианд гарсан, ямархуу хэмжээний баялгийг өгөөд өнөөдөр ашигтай ажиллуулж байгаа вэ гэдэг нь өөр ойлголт шүү. Ашигтай гээд зарим компаниудыг хэлж байгаа боловч ямар хэмжээний баялаг дээр суучхаад яах вэ ийм хэмжээний цэвэр ашигтай ажилласан бэ гэдгийг тооцвол үр ашгийг тооцвол шал өөр ойлголтууд гарч ирнэ. Тийм учраас энэ төрийн болон орон нутгийн өмчит компанийн энэ асуудал дээр онцгой анхаарах ёстой.

Тэгээд энэ хууль зүйн дүгнэлтүүдийг анхааръя. Тэгээд энэ дээр авах, гээхийн ухаанаар хандана биз. 2 дугаарт энэ тухайлан компанийн хуулийг бид гаргачихсан практиктай байхгүй юу. Манай Улсын Их Хурлын Тамгын газар энийгээ судлаач. Хөгжлийн банкны тухай хууль гэдэг чинь тухайлан компанийн хууль шүү дээ. Хөгжлийн банк гэдэг компанийн үйл ажиллагааг бүрэн зохицуулсан хууль байхгүй юу. Тэр хуулиар нь зохицуулаагүй харилцааг Төрийн болон орон нутгийн өмчийн хууль болон Иргэний хууль, Компанийн хуулиар зохицуулдаг. Яг энэ жишгээр энэ хууль орж ирж байгааг шал эсрэгээр нь бичнэ, салбар эрх зүйнүүдийг холино, энэ ажлуудыг гацаая, энэ ажлуудыг төвөг больё гэсэн байдлаар ингэж хандаж болохгүй. Тэгээд би энэ дээр Улсын Их Хурал дээр хэлнэ гэж бодож байгаа. Энэ экспертийн албыг сайжруулж чадахгүй бол энэ дүгнэлт бичдэг зүйлээ боль. Тэгээд л ерөөсөө нэг ийм утгагүй юм бичдэг. Тэгээд ингээд бүхэл бүтэн ийм ЗГ-ын ажлын хэсэг, судлаачид оролцоод ажиллачхаад ирэнгүүт нь нэгхэн хүн сууж байгаад 8 хуудас зүгээр дураараа юм биччихдэг ийм байж болохгүй байхгүй юу.

Өнөөдөр энэ хууль зүйн зөрчил гэж яриад байгаа юм. Тэргүүн ээлжид жишээ нь Хөгжлийн банкин дээр ярихад Хөгжлийн банкны хуулиар зохицуулаад, тэр хууль дээр нь байхгүй зүйлүүдийг нь Компанийн хууль, Иргэний хууль, бусад хуулиар зохицуулдаг. Тэгэхээр өнөөдрийн бид хэдийн дүгнэлт болохоор бүх хуулиуд.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Баярлалаа. Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн үг хэлнэ.

**М.Бадамсүрэн:** Тэгэхээр нэгэнт энэ хууль хуулийн төсөл орж ирж байгаа бол ерөөсөө төр яг аль салбарт ТӨК байгуулах юм гэдгийг тодорхой салбараар нь зааж өгөх ёстой. Стратегийн ийм, ийм салбаруудад л байгуулж болно, бусдад нь байгуулж болохгүй гээд 1.

2 дугаарт нь орон нутгийн эрх мэдлийг хязгаарлаж болохгүй. Яагаад гэвэл бид бүсчилсэн хөгжлийн бодлого 1, 2 дугаарт төвлөрлийг сааруулах бодлого, 3-д орон нутгийн бие даалгах энэ бодлогууд явж байгаа учраас энэ зүйл дээр нь дэмжих. Гэхдээ яг төр байгуулж байгаа энэ зүйлтэйгээ тодорхой салбарыг арай бага хүрээнд зааж өгөх 1 дүгээрт нь. 2 дугаарт нь энэ нийтийн үйлчилгээ гээд нэг үг яваад, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль дээр нийтийн зориулалттай дэд бүтэц гэж нэг яваад, тэгээд төрийн үйлчилгээ гэж нэг яваад. Тэгээд энэ чинь ингээд яг нэг нэгдсэн ийм томъёолол байхгүй байгаа. Өөрөөр хэлбэл алинаар нь ч ашиглаж болохоор. Тэгэхээр миний хэлээд байгаа зүйл нь ингээд төр байгуулах стратегийн салбараа яг энэ гээд тодорхой заагаад өгчих. Эсвэл энийг батлах эрхийг нь Засгийн газарт өгчих. Яг ийм, ийм салбарыг ТӨК байгуулж болно. Орон нутгийн өмчийн компани байгуулж болно.

2 гэвэл нийтийн үйлчилгээний салбар гээд байгаа энэ нийтийн зориулалттай дэд бүтэцтэй холбоотой өрхийн эмнэлэг, мал эмнэлэг зэрэг энэ зүйлүүдийг бид хувийн хэвшил рүү гүйцэтгэх бодлогыг зоригтой хийх ёстой. Тэгэхдээ төсөв дээрээ энэ хөрөнгийг нь тарифаар нь, хүн хүнийх нь тоогоор тооцоод, хамгийн боломжит ашигт ажиллагааны түвшинд нь энийг нь тогтоож өгөөд, энэ тарифыг нь батлаад, шаардагдах төсвийг нь батлаад, тэгээд энэ дээр нь сонгон шалгаруулалт явуулаад ингээд төр ачаанаасаа салах ёстой 1. 2 дугаарт нь хувийн хэвшил өрхийн аж ахуйг бид ийм бодлогоор дэмжихгүй бол ТӨК-ийн чинь тоо нэмэгдээд, орон нутгийн өмчит компанийн чинь тоо нэмэгдээд данхайсаар байх болно. Гэхдээ энийг хийхдээ сумын түвшинд нэг өөр, аймгийн түвшинд нэг өөр, улсын түвшин, нийслэлд нэг өөр байдлаар хийхгүй бол Төрийн хэмнэлтийн хууль шиг ийм алдаа завхралтай юм болох вий.

Төрийн хэмнэлтийн хуулиар суманд машин байхгүй гээд хориглочихсон. Ганцхан сумын Засаг дарга машинтай байна гэдэг заалт орчихсон. Гэтэл тэнд мал эмнэлгийн үйлчилгээ яаж хүрэх юм бэ? Тэгээд энийг буцаагаад өөрчлөөд, эргээд энэ амьдралд нь нийцүүлсэн шүү дээ. Тэгэхээр миний хэлээд байгаа зүйл нь ийм алдаа гаргаж, дахин Их Хурлын гишүүдийн цаг завьг гарздахгүй, та бүхэн ч гэсэн өөрсдийнхөө цаг завьг гарздахгүйн тулд энийг амьдралд нийцүүлж, сумын түвшинд ямар байх юм, аймгийн түвшинд ямар байх юм, нийслэлийн түвшинд, дүүргийн түвшинд, улсын түвшинд ямар байх юм бэ гэдгийг тодорхой болгож өгөхгүй бол энэ зүйл хүндрэл үүснэ. Би энийг баталгаатай хэлье. Яагаад гэвэл энэ хууль чинь амьдралд нийцэж байх ёстой. Дээр нь хувийн хэвшлээ дэмжих энэ Үндсэн хуулийн заалтаа бид 100 хувь хэрэгжүүлэх ёстой.

Тэгэхгүй бол өнөөдөр мал эмнэлгийн үйлчилгээг чанартай хүргэхийн тулд тарифыг нь бид тодорхой хэмжээнд нэмэгдүүлж өгөх ёстой. Гэтэл яг үнэндээ энэ байтугай зардлыг гаргадаг л юм байна лээ шүү дээ. Тэр юу билээ нөгөө эрчим хүчний сурталчилгаа хийхэд билүү 8, 10 хэдэн тэрбум төгрөг гаргадаг юм байна лээ. Тэр мөнгө чинь энэ мал эмнэлгийн үйлчилгээ, хүн эмнэлгийн үйлчилгээндээ хувийн хэвшил гүйцэтгэж байгаа үйлчилгээндээ очих юм бол энэний үйлчилгээний чанар хамаагүй сайжирна. Тийм учраас энэ зүйлийг хийхгүйгээр энэ хууль яг энэ төслөөрөө явах юм бол энэ хууль амьдралд хэрэгжихгүй. Би энийг баталгаатай хэлье. Энийг ийм алдаатай гарахаас нь сэргийлж өнөөдөр би энэ саналыг хэлье гэж хэлж байгаа юм. Би чуулган дээр ч гэсэн энэ саналаа хэлнэ. Ингээд та бүхэн ингээд орон нутгаас ядаж санал авч хэлэлцүүлэг хийсэн юм уу? Хийгээгүй.

**Р.Сэддорж:** Гишүүд үг хэлж дуусаж байна. Өнөөдрийг хүртэл Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн тухай хуулиар ингээд явж байгаа. Тэгээд энэ хууль орж ирснээрээ төрийн өмчийн компаниудаа ялгаж анхаарал хандуулж байна гэж ойлгож байгаа. Тэгээд хуучин хууль маань зэрэгцээд явна. Тэгээд тэр хуучин Компанийн тухай хуульдаа ч гэсэн Төрийн өмчийн хороо болон ЗГ-аас сайжруулах шаардлага байгаа. Тэгээд энэ 199 ТӨК болон төрийн өмчит үйлдвэрийн газрын 43 компани нь ач алдагдалтай ажиллаж байгаа энэ нөхцөл байдалд дүгнэлт хийж, энэ өөрчлөлтийг оруулж, шинэ хуульд оруулж байгаа. Гишүүд маш чухал, чухал санаануудыг гаргаж байна. Тэгээд болж бүтэж байгаа юмнуудаа татаад унагачих вий дээ. Болохгүй байгаа зүйл рүүгээ анхаарах нь зөв, болж бүтэж байгаа тэр компаниудаа татаад нийлүүлээд, устгаад хаячих вий дээ гэсэн ийм санаануудыг бол их гаргаж байна. Тэгээд энийг цаашдаа байгуулагдах ажлын хэсэг, энд ирсэн ажлын хэсгийнхэн онцгой анхаарч ажиллахыг хүсэж байна.

Иргэд бол цаашдаа төр оролцохгүйгээр сайн явахгүй байгаа компаниудыг салбаруудыг нэрлээд байгаа шүү дээ. Төр хамгийн сайн, хамгийн муу менежер гэдэг энэ ойлголтыг PR маягаар явуулсан. Гэхдээ төр бол сайн ажиллаж байгаа төрийн компаниуд зөндөө байна гэдгийг сая Сайнзориг гишүүн хэллээ. Тэгэхээр ямар, ямар салбарт төрийн өмчийн оролцоо байх юм, ямар, ямар салбарт орон нутгийн өмчийн оролцоо байх юм, тэгээд иргэд юу хүсэж байна гэхээр энэ орон нутаг, иргэд тэр хувьцаа яаж эзэмших юм, Монголын хөрөнгийн бирж дээр энэ ТӨК-удын хувьцаа арилжаалагдах юм уу, тэд нарыг их сонирхож байгаа. Тэгэхээр иргэддээ энэ хувьцаа эзэмших, оролцох, хамтарч оролцох, ААН-үүд оролцох энэ боломжуудыг хувьцаагаа хуваах байдлаар хамтран эзэмших байдлаар төр, хувийн хэвшил хамтран хувьцаа эзэмших байдлаар энэ хуульд оруулж болох бүх боломжуудыг оруулаасай гэж хүсэж байна.

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалт явагдана. Гишүүд идэвхтэй байрлалаа эзлэхийг хүсье. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт заасныг үндэслэн хууль, тогтоолын төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна.

1.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулья. Санал хураалт. 10 хүн дэмжиж, 58,8 хувиар санал дэмжигдлээ. Мөнхсоёл гишүүний, Мөнхсоёл гишүүний аппарат нь ажиллахгүй байгаа тул дэмжсэнээр протокол тэмдэглэе.

2.Хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 12 гишүүн буюу 70,6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Хамт өргөн мэдүүлсэн Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 11 гишүүн буюу 64,7 хувийн саналаар санал дэмжигдлээ. Мандхай гишүүний төхөөрөмж ажиллахгүй байгаа тул дэмжсэнээр протоколд тэмдэглэе.

4.Хамт өргөн мэдүүлсэн Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 12 гишүүн буюу 70,6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Хамт өргөн мэдүүлсэн Дампуурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 11 гишүүн буюу 64,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 10 гишүүн буюу 58,8 хувийн саналаар санал

дэмжигдлээ. Мандхай гишүүнийг, мөн Энхцэцэг гишүүн нар төхөөрөмжийн улмаас санал өгөгдөөгүй учраас санал дэмжсэнээр тэмдэглээ.

7.Хамт өргөн мэдүүлсэн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 11 гишүүн буюу 64,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Хамт өргөн мэдүүлсэн Инновацын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 9 гишүүн буюу 52,9 хувийн саналаар санал дэмжигдлээ. Гишүүд санал хураалтад идэвхтэй оролцоорой.

9.Хамт өргөн мэдүүлсэн Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 10 гишүүн буюу 58,8 хувийн саналаар санал дэмжигдлээ. Сайнзориг гишүүнийг дэмжсэнээр протоколд тэмдэглээ.

10.Хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 10 гишүүн буюу 58,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 11 гишүүн буюу 64,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 11 гишүүн буюу 64,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13.Хамт өргөн мэдүүлсэн Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 11 гишүүн буюу 64,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14.Хамт өргөн мэдүүлсэн Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 12 гишүүн буюу 70,6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15.Хамт өргөн мэдүүлсэн Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 12 гишүүн буюу 70,6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

16.Хамт өргөн мэдүүлсэн Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн

томъёоллоор санал хураалт. 11 гишүүн буюу 64,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

17.Хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 12 гишүүн буюу 70,6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

18.Хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 11 гишүүн буюу 64,7 хувийн саналаар санал дэмжигдлээ. Сайнзориг гишүүнийг дэмжсэнээр протоколд тэмдэглэе.

19.Хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 9 гишүүн буюу 52,9 хувийн саналаар санал дэмжигдлээ. Гишүүд идэвхтэй оролцье.

20.Хамт өргөн мэдүүлсэн Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 9 хүн буюу 52,9 хувийн саналаар санал дэмжигдлээ. Техникийн хүмүүс гишүүдийн төхөөрөмж зарим нь ажиллахгүй байна.

Санал хураалт 21. Хамт өргөн мэдүүлсэн “Хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 11 гишүүн буюу 64,7 хувийн саналаар санал дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг танилцуулна. Хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэж дууслаа.

12.33 цаг

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж, хуралдаан үүгээр өндөрлөж байна. Хуралд идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдэд баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

